



МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
АКАДЕМИ

# 2014

ТОВЧ ТАЙЛАН

# ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТАЛААР	7
ТӨР ЗАСГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАЛААР	20
ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАЛААР	26
ИХ ДЭЭД СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАЛААР	30
ИХ ЧУУЛГАН	32
БАГА ЧУУЛГАН	33
БИОЛОГИЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН	34
ГЕОЛОГИ ГАЗАРЗҮЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН	37
ФИЗИК МАТЕМАТИК ХИМИЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН	39
ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН	41
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН	43
МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ АКАДЕМИ	46
ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ	48

ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ	49
ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА	58
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ	62
ИННОВАЦИ	77
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРТАЛЧИЛГАА	79
САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР	87
ДҮГНЭЛТ	89
ЗОРИЛТ	90



## ТОВЧИЛСОН ҮГ

БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
МУИС	Монгол улсын их сургууль
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ШУС	Шинжлэх ухааны сургууль
TWAS	Дэлхийн хөгжиж буй орнуудын шинжлэх ухааны академи
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
БОНХАЖЯ	Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яам
ССАЖЯ	Соёл спорт аялал жуулчлалын яам
УУЯ	Уул уурхайн яам
БОХХААБХ	Байгал орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо
ГМС	Газарзүйн мэдээллийн систем
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МАУА	Монголын анагаах ухааны академи
МХААШУА	Монголын хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академи
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
МАУ	Монголын анагаах ухаан
АУХ	Анагаах ухааны хүрээлэн
МОХБИБЭ	Монгол Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедиц
ЦТБХГБ	Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээний байгууллага
УТХГХЗ	Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
ICSU	Шинжлэх ухааны олон улсын зөвлөл
KAST	Солонгосын шинжлэх ухаан технологийн академи
ASM	Малайзын Шинжлэх ухааны академи
CERN	ЕвропынЦөмийн судалгааны төв



## ӨМНӨХ ҮГ

---

Монгол улсын Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газраас 2013-2017 онд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны шинэчлэлийн чиглэлээ хатуу дэд бүтцийг сайжруулах, зөөлөн дэд бүтцээ чанаржуулах, менежментийн шинэчлэл хийх, их сургуулиудтай үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор хамтарсан хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх гэж тодорхойлон, жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

Энэ зорилтынхоо хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль болон Инновацийн тухай хууль, ШУА-ийн дүрэм болон бусад хууль, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулан, нийт эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй нягт хамтран ажиллаж байна.

Тэргүүлэгчдийн газар нь ШУА-ийн Их, бага чуулганы үйл ажиллагаа, харьяа хүрээлэн, төвийн судалгааны чиглэлийг тогтоох, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, төр, засагт зөвлөмж хүргэх, гадаад харилцааны хүрээнд дэмжлэг үзүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ 2014 оныг **“Чанарыг дээшлүүлэх, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах жил”** болгон зарлаж шинэ мэдлэг бүтээхийн зэрэгцээ хэрэглээнд нэвтрүүлэхэд онцгойлон анхаарч ажиллав.

Удирдлагын түвшинд бага чуулган, хүрээлэнгийн захирал, удирдлага залуужиж, менежментийн үйл ажиллагаа шинэчлэгдэж эхэлснийг тэмдэглэж байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хамт олон 2014 онд ШУА-ийн ерөнхийлөгчийн БШУ-ны сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу 15 тусгай захиалгат, 198 нийт ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд нь удирдлага, зохион байгуулалтын болон үйл ажиллагааны бүхий л талын дэмжлэг үзүүлэн өндөр түвшинд чармайн ажиллав.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас санаачлан БСШУЯ, БОНХАЖЯ, ГХЯ, ХХААЯ, ЭХЯ, ЭМСЯ, БХБЯ зэрэг яам, төрийн байгууллагуудтай эрхэлдэг асуудлын хүрээнд судалгаа, үйлдвэрлэл, инновацийн асуудлаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан 29 ажлыг хэрэгжүүлэх, төрийн яамд, орон нутгийн удирдлагын байгууллагатай хамтран тэдний захиалгат, ялангуяа орон нутгийн хөгжилд чухал шаардлагатай ажлыг гүйцэтгэх зорилт дэвшүүлэн, Ховд, Архангай, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий зэрэг аймгуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.



ШУА-ийн үйл ажиллагааны нэг гол чиглэл бол дэлхийн шинжлэх ухааны сүлжээг ашиглан эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын судалгаа шинжилгээний ажлыг менежмент арга зүйгээр дэмжин зохион байгуулах явдал бөгөөд манай харьяа хүрээлэн, төвийн 117 эрдэмтэн судлаач олон улсын болон бүс нутгийн төсөл, хөтөлбөрт хамтран хэрэгжүүлэгчээр амжилттай оролцож байна. Зөвхөн 2014 онд Тайвань, Итали, Казахстан, АНУ зэрэг гадаадын 9 орны 13 эрдэм шинжилгээний байгууллагатай шинээр гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулан ажиллав.

Эцэст нь дээрх ажлыг бүхий л түвшинд зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд гадаад харилцааныхаа боломжид түшиглэн дэмжлэг үзүүлэх зэрэг олон чиглэлээр ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, түүний ажилтнууд үр бүтээл, санаачлагатай ажиллаж ирснийг тэмдэглээд Шинжлэх ухааны Академийн 2014 оны товч тайланг танилцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ

Б. ЭНХТҮВШИН



## УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТАЛААР

ШУА-ийн үйл ажиллагааг аргазүйн нэгдсэн удирдлагаар хангаж, хэвийн явуулах зорилгоор ШУА-ийн Их, бага чуулган, Тэргүүлэгчдийн хурлын бэлтгэлийг хангаж, хамтран зохион байгуулах, тэдгээрээс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллав.

2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ШУА-ийн харьяа 22 байгууллагад 1052 албан хаагч байгаагаас 793 нь эрдэм шинжилгээний ажилтан, түүний дотор академич 30, доктор (Sc.D) 33, доктор (Ph.D) 218, магистр 290 ажиллаж байна. Нийт ажиллагсадын дотор 35 хүртэл насны залуучууд 52,7 хувь, 35-аас 50 насных 25,3 хувь, 50-иас дээш насныхан 22,6 хувийг тус тус эзлэж, дундаж нас 39, харьяа байгууллагуудын захирлын дундаж нас 54 байв. (ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийн нийт албан хаагчдын тоо ба демографын бүтцийг хүснэгт 1, эрдэм шинжилгээний ажилтны эрдмийн чадамжийн зарим үзүүлэлтийг хүснэгт 2-оор харуулав).

2014 оны байдлаар ШУА-ийн хэмжээнд 290 магистрийн зэрэгтэй судлаач ажиллаж байгаагийн 128 нь докторантурт, үүнээс 98 нь гадаадад, 181 бакалаврын зэрэгтэй ажилтан ажиллаж байгаагийн 101 нь магистрантурт, үүнээс 14 нь гадаадад тус тус суралцаж байна.

ШУА-ийн харьяа хүрээлэн, төвийн захирлын сонгуулийг 2014 оны 3 дугаар сарын 10-ны өдөр явуулав. Энэ удаагийн сонгуулиар 17 хүрээлэн, төвийн захирлын орон тоон дээр 40 эрдэмтэн нэр дэвшүүлж материалаа ирүүлэв. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн Тэргүүлэгч гишүүдийн нууц санал хураалтаар олонхийн санал авсан нэр дэвшигчдийг хүрээлэн, төвийн захирлаар томилов. Үүнд:

Хими, хими-технологийн хүрээлэнгийн захирлаар академич Д.Батсүрэн, Технологийн инкубаторийн захирлаар Ч.Батсүх, Биологийн хүрээлэнгийн захирлаар академич Ц.Жанчив, Ботаникийн хүрээлэнгийн захирлаар академич Ч.Дугаржав, Геоэкологийн хүрээлэнгийн захирлаар доктор Ж.Цогтбаатар, Эрдэс боловсруулалт технологийн хүрээлэнгийн захирлаар доктор Х.Бадамхатан, Түүхийн хүрээлэнгийн захирлаар доктор С.Чулуун, Археологийн хүрээлэнгийн захирлаар доктор Д.Цэвээндорж нар тус тус улиран сонгогдов. Харин Физик технологийн хүрээлэнгийн захирлаар Цөмийн энергийн газрын Цацрагийн хяналтын шинжилгээ, тохируулгын лабораторийн эрхлэгч, доктор Д.Орлох, Одон орон, геофизикийн судалгааны төвийн захирлаар тус төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор С.Дэмбэрэл, Информатикийн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Б.Нэргүй, Байгалийн шинжлэлийн



нэгдсэн лабораторийн захирлаар доктор Д.Гүнбилэг, Газарзүйн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор С.Энх-Амгалан, Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Д.Одгэрэл, Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн захирлаар академич Г.Чулуунбаатар, Олон улс судлалын хүрээлэнгийн захирлаар доктор Д.Шүрхүү, Палеонтологийн төвийн захирлаар тус төвийн лабораторийн эрхлэгч, доктор Х.Цогтбаатар нар шинээр сонгогдон томилогдов.



Байгалийн шинжлэлийн нэгдсэн лабораторийн захирлаар томилогдсон Д.Гүнбилэг өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул тус лабораторийн захирлын сонгон шалгаруулалтыг дахин явуулж лабораторийн захирлаар доктор П.Алтанцог 2014 оны 11 сараас томилогдон ажилласан байна.

Хүрээлэн төвийн эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дотоод бүтцийг шинэчлэх ажлыг хүрээлэнгүүдийн санал дээр тулгуурлан зохион байгуулав.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас санаачлан салбарын хүний нөөцийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын бодлого зорилтыг зөв оновчтой тодорхойлох зорилгоор Монголын хүний нөөцийн академитай хамтран “ШУА-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулах ажлыг эхлүүлсэн ба одоо төгсгөлийн шатандаа явж байна. Энэ ажлын хүрээнд судалгааны багийнхан манай бүх хүрээлэн төвүүдээр явж захирал удирдлагууд болон асуудал хариуцсан хүмүүстэй уулзан санал дүгнэлтээ гаргасан байна.

2014 онд ШУА-ийн гишүүдийн зөвлөгөөнийг 2 удаа, хүрээлэн, төвийн захирлуудын уулзалтыг цаг үеийн асуудлаар 5 удаа зохион байгуулжээ. ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурал нь академийн харьяа хүрээлэн төвийн захирлуудын 4 жилийн тайлан, мөрийн хөтөлбөрийн биелэлт, Бага чуулганы гишүүний сонгуулийн дүн, ШУА-ийн Эрдэм шинжилгээний номын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай, 2015 оноос хэрэгжүүлэх грант төслийн тухай, Шилдэг залуу эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдыг Монгол улсын





Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэх зэрэг асуудлаар 9 удаа хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргав.



МУ-ын Засгийн газраас УИХ-д өргөн бариад буй Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөлд санал боловсруулах ажлын хэсэг томилон ажиллуулж ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, салбарын Бага чуулган, хүрээлэн, төвийн эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудын саналыг тусган БСШУЯ-д хүргүүлэв.

БШУЯ-ны Шинжлэх ухааны бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх журмыг шинэчлэх болон эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд Гарааны компани байгуулах журам боловсруулах зэрэг ажилд хамтран оролцож ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, Бага чуулганууд, хүрээлэн, төвийн эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудын саналыг тусгахад анхаарч ажиллав.

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны байнгын хорооны “Шинжлэх ухааны байгууллагуудыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг гаргах талаар санаачлагатай ажилласны дүнд энэ оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 07 тоот тогтоол гарч, түүнд эрдэм шинжилгээний байгууллагын санхүүгийн бие даасан байдлыг хангах, эрдэм шинжилгээний ажилтны ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын үр дүнтэй холбон урамшуулал олгох тогтолцоо бүрдүүлэх талаар тодорхой заалтууд тусгагдан хэрэгжиж эхлээд байна.

ШУА-ийн харьяа хүрээлэн, төвийн эрдэмтэн судлаачид өөрийн мэргэжлийн чиглэлээр их, дээд сургуулиудад хичээл заах, бакалавр, магистр, докторын ажил удирдаж хамгаалуулах, оюутны үйлдвэрлэлийн болон танилцах дадлага удирдах, сурах бичиг гарын авлага бэлтгэх, хянан тохиолдуулах, үндэсний болон олон улсын хэмжээний



эрдэм шинжилгээний хурал хамтран зохион байгуулах зэрэг олон хэлбэрээр их дээд сургуулиудтай хамтран ажиллаж байна.

Энэ онд Одон орон, геофизикийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Цоггэрэл, Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Аззаяа, Б.Дархижав, Ц.Цэдэндорж, Б.Амарсанаа, М.Хүрэлбаатар, Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Лхагвасүрэн, Б.Түвшинтөгс, Б.Цэрэндулам, Г.Майнжаргал, Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.Очгэрэл, Д.Өсөхжаргал, Ц.Хонгор, Э.Ариунболд, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.Мөнхцэцэг, Ц.Батдорж, Д.Уртнасан, Ч.Заяасүрэн, Э.Баярчимэг, Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.Тунгалаг, Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Соёлмаа нарын 19 судлаач доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалав.

Мөн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан А.Даваасүрэн “Монгол Улсын эдийн засгийн орон зайн удирдлага зохион байгуулалт, онол ба практик” сэдвээр эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэг, Анагаахын Шинжлэх ухааны Үндэсний Их Сургуулийн профессор Г.Отгон “Монголын экологийн янз бүрийн бүсийн хүүхдийн бие бялдрын хөгжил ба физиологийн зарим үзүүлэлтүүд” сэдвээр анагаахын шинжлэх ухааны докторын зэргийг тус тус хамгаалав.

2014 онд манай судлаачдын хөдөлмөр бүтээлийг өөрийн оронд төдийгүй олон улсын хэмжээнд үнэлсэн, урамшуулсан жил болж өнгөрлөө.

ФТХ-ийн Онолын физикийн салбарын эрхлэгч, академич Х.Намсрайг Монгол бахархлын өдрийг тохиолдуулан Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд, тэргүүн зэргийн “Чингис хаан” одонгоор шагнасан нь шинжлэх ухааны салбарт анх удаа уг одонг хүртээсэн үйл явдал болов.



Хэл зохиолын хүрээлэнгийн Монголын нууц товчоо судлалын төвийн захирал,

академич Д.Цэрэнсодномыг Олон улсын Алтай судлалын Байнгын бага хурлаас “Алтан медаль”-иар шагналаа. Тэрээр энэхүү дэлхийн хэмжээний нэр хүндтэй шагналаар шагнагдсан хоёр дахь Монгол эрдэмтэн болж байна.



ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич Ж.Тэмүүжин Хумбольдын сангийн Георг Форстерийн шагнал хүртлээ. Георг Форстерийн шагнал нь ХБНГУ-ын хамгийн нэр хүнд бүхий олон улсын судалгааны шагналд тооцогддог. Энэхүү шагналын болзол нь судлаачийн шинэ онол, тулгуур нээлт, шинэ санаа нь тухайн шинжлэх ухааны салбарын хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэсэн байх ёстой бөгөөд өөрийн улсын хөгжлийг түргэсгэх, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх ёстой байдаг байна.

Доктор С.Чулуун ОХУ-ын Дорно дахины судлалын дээд шагналаар, доктор Н.Эрдэнэчимэг Азийн шилдэг эмэгтэй судлаач шагналаар тус тус шагнагдаж, зарим академич БНСУ, ОХУ-ны нэр хүндтэй их сургуулийн доктор, профессор цол хүртсэн байна.

Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Өлзийбаатар “Монголчууд цахим түүх бүтээл”-ээрээ Жэк Уэтэрфордын нэрэмжит шагналыг хүртсэн байна.

Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн захирал, академич О.Төмөртоогоо “Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн”, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Д.Оролмаа, Физик технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Д.Нямаа, доктор С.Доржханд, Палеонтологийн төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,





доктор Ё.Ханд нар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, Палеонтологийн төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Н.Ичинноров, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор О.Самбуудорж, доктор Э.Дондов, доктор Б.Түвшинтөгс, Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Г.Одонтуяа, доктор М.Думаа, доктор Ч.Отгонбаяр, Байгаль шинжлэлийн нэгдсэн лабораторийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор А.Чимэдцогзол нар “Алтан гадас” одонгоор шагнагдав.



Ботаникийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч И.Түвшинтогтох “Монгол орны хээрийн ургамал” бүтээлээрээ “Шинжлэх ухааны шилдэг бүтээл”-ийн 2 дугаар байрын шагнал, Түүхийн хүрээлэнгийн захирал С.Чулуун нарын хамтын бүтээл болох “Монголчууд XVII-XX зууны эхэн” бүтээлээрээ тусгай шагналыг хүртлээ.



Боловсрол, шинжлэх ухааны яам, ШУА, Монголын залуу эрдэмтдийн холбоо, ШУТСан, Монголын үндэсний томоохон их сургуулиудтай хамтран жил бүр зохион байгуулдаг Монголын залуу эрдэмтэн судлаачдын “Хүрэлтогтоот-2014” эрдэм шинжилгээний бага хурлыг ШУА-ийн ООГФСТөвийн харьяа Одон орон судлах Хүрэлтогтоот төвд 14 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний бага хурал анагаах ухаан, байгалийн ухаан, геологи газарзүй, хөдөө аж ахуй, техник технологи, нийгмийн ухаан гэсэн

6 салбараар зохион байгуулагдаж нийт 529 залуу судлаач эрдэмтэд оролцов. Салбар хуралдаан бүрээс 2 буюу нийт 12 шилдэг залуу судлаачийг тодруулсан бөгөөд ШУА-ийн Геологи эрдэс баялгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан О.Одбаяр “Монгол орны газрын ховор элементийн ордуудын эрдэслэг бүрэлдэхүүний харьцуулалт судалгаа” сэдвээр шилдэг залуу судлаачдын нэг боллоо.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Мод тарих үндэсний өдөр” 5 дугаар сарын 10-ны өдөр тохиож, ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд “ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт мод тарьж, тус цэцэрлэгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулцгаая” уриан дор нэгдэн ажиллав.



Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран сайн дураар цус бэлэглэх “Халуун сэтгэл” өдөрлөгийг 2014 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр зохион байгуулав.





Одон орон геофизикийн судалгааны төвийн дэргэд Одон орон судлал ба Сансар, од эрхсийн ордон “Астропарк”-ийг ашиглалтанд оруулж, астрономи сонирхогчдын уулздаг газар боллоо.



Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан Сансар од эрхсийн ордонд Монгол Улсын сансрын нисгэгч, Хөдөлмөрийн баатар, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор профессор М.Ганзоригт зориулсан Хүндэтгэлийн самбар байрлуулав.



Монгол Улсын Шинжлэх ухааны Академи ба Дэлхийн Шинжлэх Ухааны Академи (TWAS)-тай хамтран, 1991 оноос одоог хүртэл физик, хими болон математик, биологи гэсэн чиглэлээр ээлжлэн шалгаруулж, шалгарсан залуу судлаачдыг тус бүрийг 1000 ам.доллараар шагнадаг уламжлалтай. Өнгөрсөн 20 гаруй жилд нийт 44 залуу судлаачид



Дэлхийн гуравдагч орны академийн энэхүү шагналыг хүртсэн байна. Энэ жил тус нэр хүндтэй шагналаар МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн дэд профессор Б.Мөнхбат, Шинжлэх ухаан технологийн «Оюун онош» төвийн ерөнхий захирал, Монголын анагаах ухааны холбооны ерөнхийлөгч Г.Цэрэнчунт нар шагнагдсан байна.



Залуу эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдад олгодог Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 2014 оны шагналыг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Х.Алтанзул “Монгол орны зарим ховор, нэн ховор эмийн ургамлын биотехнологийн судалгаа” бүтээлээрээ, Анагаахын Шинжлэх ухааны Үндэсний Их сургуулийн Дархлаа судлалын тэнхмийн багш, доктор Т.Хонгорзул “Альфа-гөлгөр булчингийн актины илрэлээр тунгалагийн булчирхайн шинэ бүтцийн эсийг нээж илрүүлсэн дүн” бүтээлээрээ, МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн багш, доктор Ц.Соёл-Эрдэнэ “ Антарктид дахь цагаан алтны бүлгийн элементүүдийн тунадасжилт, тэдгээрийн эх үүсвэрийн судалгаа” бүтээлээрээ тус тус хүртлээ.





ШУА-иас залуу судлаачдыг дэмжих, тэдний чадавхижуулах чиглэлээр олон талын үйл ажиллагаа явуулж байна. Эрдэм шинжилгээний залуу ажилтан нарт орчин үеийн судалгааны арга зүй эзэмшүүлэх, тэдний гадаад хэлний мэдлэгийн түвшин дээшлүүлэх зорилгоор жил бүр эрдэм шинжилгээний ажлын судалгааны арга зүйн болон гадаад хэлний сургалтыг БСШУ-ны яамтай хамтран зохион байгуулж ирлээ.

Эрдэм шинжилгээний ажилтан нар эрдэм шинжилгээний өгүүллийг хэрхэн бичих, мэдээлэлд хэрхэн дөт замаар хүрэх, эрдэм шинжилгээний өгүүлэл бүтээлээ гадаад дотоодын нэр хүнд бүхий сэтгүүлд яаж хэвлүүлэх талаар танилцуулах зорилгоор Springer Science Business Media компанийн дэмжлэгтэйгээр Нээлттэй мэдээллийн өдөрлөгийг зохион байгууллаа.

Салбарын бага чуулганууд залуу судлаачдад зориулан уулзалт хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний бага хурал, семинаруудыг чиглэл чиглэлээр зохион байгууллаа.

ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүд залуусаа идэвхижүүлэн баг болгон ажиллуулах зорилгоор залуучуудын зөвлөл, клуб байгуулан ажиллуулж байна.

Линдаугийн сантай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу залуу судлаачдыг ШУА-ийн Залуу эрдэмтдийг дэмжих сангаас шалгаруулан санхүүжүүлж Германд болдог Нобелийн шагналтнуудын жил бүрийн уулзалт, лекцэнд оролцуулж байна.

Ахмад эрдэмтдийн туршлагыг залуу үед өвлүүлэх тэдний арвин туршлагаас суралцан хөгжих боломжийг залуу үед олгох зорилгоор ШУА-ийн гишүүд (академичд)-ийн цуврал лекцийг тогтмол зохион байгуулж ирлээ. Судлаачдын мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэм” клубийн үйл ажиллагааг идэвхижүүллээ. ШУА-ийн тогтмол хэвлэл “Эрдэм” сонинд “Залуу судлаачдыг танилцуулж байна” буланг нээж тогтмолжууллаа.

2014 оны зорилтын хүрээнд Шинжлэх ухаан, технологийн салбарын статистик үзүүлэлтийг гаргах, фраскатигийн аргачлалыг хэрэглэх зорилгоор ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнтэй холбоо тогтоож ажиллаж, ЮНЕСКО, БШУЯ, ШУА болон ШУТИС хамтран “Шинжлэх ухаан, технологи, инновацийн шалгуур үзүүлэлт” сургалт семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Бодлого боловсруулах үйл ажиллагаанд шинжлэх ухааны статистикийн мэдээллийн систем үзүүлэлтийг боловсронгуй болгож нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүнчлэн шинжлэх ухааны статистикийн мэдээллийн үзүүлэлт аргачлалыг олон улсын жишигт ойртуулж, статистикийн мэдээллийн маягт, аргачлалуудыг ЮНЕСКО болон бусад олон улсын хэмжээнд нийтлэг мөрддөг баримт бичиг стандартад нийцүүлэн дэс дараатай шинэчлэх арга хэмжээ авах зорилт тавин ажиллахад чухал үр дүнтэй сургалт болж олон улсын жишиг баримт бичиг болох Фраскати болон Ослогийн гарын авлагуудыг танилцуулав.

Судалгааны ажлын үр дүнг олон улсын түвшинд нийтийн хүртээл болгох зорилгоор



Proceedings of the Mongolian Academy of Sciences, Mongolian Journal of International Affairs, Mongolian Journal of Chemistry зэрэг сэтгүүлийг цахим хувилбарт оруулан онлайн хувилбарыг Олон улсын шинжлэх ухааны холбоо (ICSU)-ийн INASP хөтөлбөр, ([www.mongoliajol.info](http://www.mongoliajol.info))-тай хамтран байршуулж, олны хүртээл болгох ажлыг эхлүүлсэн бөгөөд цахим хуудсанд байршуулснаас хойш ШУА-ийн Мэдээ сэтгүүлээс нийт 46'537 удаагийн татан авалт хийгдсэн байна.



ШУА-ийн дэргэдэх “Эрдэм” клуб эрдэмтдийн санал дүгнэлтийг бодлого боловсруулагчид хүргэх зорилго бүхий лекторийг үргэлжлүүлэн зохион байгуулж, уур амьсгалаас үүдэлтэй хөдөөгийн эрсдэл, ядуурлыг бууруулах асуудал, ус, байгалийн бэлчээр ашиглах хамгаалах, машины үйлдвэрлэл хөгжүүлэх гэхчилэн 10 гаруй асуудлыг хэлэлцэв.





**Хүснэгт 1. ШУА-ийн хүрээлэн, төвүүдийн нийт албан хаагч ба демографийн бүтэц  
(2014 оны 12 дугаар сарын байдлаар)**

№	Хүрээлэн, төвийн нэр	Нийт албан хаагч	Үүнээс эмэгтэй	ЭША	35 хүртэлх насны	35-50 насны	50-иас дээш насны	Дундаж нас
1	Физик технологийн хүрээлэн	100	37	71	40	7	24	40
2	Одон орон, геофизикийн судалгааны төв	91	31	70	35	28	7	37
3	Информатикийн хүрээлэн	42	16	28	21	6	1	31
4	Хими, хими технологийн хүрээлэн	104	63	83	42	20	21	39
5	Биологийн хүрээлэн	76	46	63	35	13	15	39
6	Ботаникийн хүрээлэн	88	48	66	40	11	15	33
7	Гео-экологийн хүрээлэн	93	53	66	40	13	13	36
8	Газарзүйн хүрээлэн	67	28	56	41	5	10	31
9	Геологи, эрдэс баялгийн хүрээлэн	35	19	27	14	6	7	38
10	Палеонтологийн төв	47	19	29	16	3	10	42
11	Эрдэс боловсруулалт технологийн хүрээлэн	15	8	8	3	-	5	48
12	Хэл зохиолын хүрээлэн	49	22	45	13	20	12	43
13	Түүхийн хүрээлэн	51	18	36	11	13	12	48
14	Археологийн хүрээлэн	46	6	39	23	15	1	35
15	Философи, социологи, эрхийн хүрээлэн	35	17	30	10	10	10	39
16	Олон улс судлалын хүрээлэн	40	22	36	13	11	12	42
17	Үндэсний хөгжлийн хүрээлэн	19	9	14	3	10	1	35
18	Баян-Өлгий аймаг дахь нийгэм, эдийн засгийн судалгааны төв	16	6	14	10	3	1	33
19	Технологийн инкубатор	10	5	4	1	3	-	37
20	Байгаль шинжлэлийн нэгдсэн лаборатори	9	6	1	-	-	1	52
21	Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв	13	4	7	4	2	1	40
22	Эрдэм шинжилгээний номын сан	6	5	-	3	2	1	33
	<b>Нийт тоо, хувь</b>	<b>1052</b>	<b>488</b>	<b>793</b>	<b>418 52,4%</b>	<b>201 25,3%</b>	<b>180 22,3%</b>	<b>39</b>



**Хүснэгт 2. ШУА-ийн хүрээлэн, төвүүдийн эрдэм шинжилгээний ажилтны чадамж  
(2014 оны 12 дугаар сарын байдлаар)**

№	Хүрээлэн, төвийн нэр	Академич	Доктор (Sc.D)	Доктор (Ph.D)	Доктор болон түүнээс дээш цолтой ЭША (%)	Магистр	Докторант
1	Физик технологийн хүрээлэн	5	4	16	35,2	27	9
2	Одон орон, геофизикийн судалгааны төв	-	-	11	15,7	27	11
3	Информатикийн хүрээлэн	2	2	5	32,1	12	5
4	Хими, хими технологийн хүрээлэн	6	2	30	45,8	27	7
5	Биологийн хүрээлэн	4	2	17	36,5	27	12
6	Ботаникийн хүрээлэн	2	4	20	39,4	36	6
7	Гео-экологийн хүрээлэн	-	-	15	22,7	35	11
8	Газарзүйн хүрээлэн	1	3	12	28,6	23	4
9	Геологи, эрдэс баялгийн хүрээлэн	1	-	9	37,0	3	3
10	Палеонтологийн төв	1	3	4	27,6	8	2
11	Эрдэс боловсруулалт технологийн хүрээлэн	-	-	1	12,5	5	3
12	Хэл зохиолын хүрээлэн	3	2	21	57,8	5	7
13	Түүхийн хүрээлэн	2	1	21	66,7	3	5
14	Археологийн хүрээлэн	-	1	11	30,8	7	13
15	Философи, социологи, эрхийн хүрээлэн	2	3	5	33,3	5	12
16	Олон улс судлалын хүрээлэн	-	5	10	41,7	19	9
17	Үндэсний хөгжлийн хүрээлэн	-	-	4	28,6	13	6
18	Баян-Өлгий аймаг дахь нийгэм, эдийн засгийн судалгааны төв	-	1	3	28,6	6	2
19	Байгаль шинжлэлийн нэгдсэн лаборатори	-	-	2	-	1	
20	Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв	1	-	1	14,3	1	1
	Нийт	30	33	218	33.4%	290	128



## ТӨР ЗАСГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАЛААР

Шинжлэх ухааны Академи нь Судар бичгийн хүрээлэнгийн үеэс эхлэн монголын эрдэмтдийн төлөөллийн байгууллага байж, эрдэм судлалын ажлыг удирдан зохион байгуулж, шинжлэх ухааны болоод улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж, бодлого боловсруулагчдад зөвлөмж өгсөөр ирсэн юм. Энэ онд бид засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан шинжлэх ухааны болоод шинжлэх ухаанч оролцоо шаардсан 29 ажлыг төрийн яамдтай хамтран шийдвэрлэх, орон нутгийн хөгжилд шаардлагатай судалгаа шинжилгээний ажлыг захиалгаар гүйцэтгэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

2014 онд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд чиглэсэн 44 үр дүнг холбогдох газруудад зөвлөмжийн болон бусад хэлбэрүүдээр хүргүүлсэн байна. Тухайлбал:

Нийгмийн ухааны салбарын бага чуулганы эрдэмтдийн багаас “Монгол улсын эдийн засгийн өнөөгийн хүндрэлийг даван туулах, цаашдын хөгжилд ахиц дэвшил гаргах тухай зарим санал” зөвлөмж боловсруулан МУ-ын Засгийн газарт хүргүүлэв.

Түүнчлэн:

- “Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын зөвлөмж;
- “Монгол улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам” эрдэм шинжилгээний бага хурлын зөвлөмж;
- Ази–Европыг холбох Эрээнцав-Бичигт-Зиньжоу эдийн засаг, тээврийн шинэ хонгил байгуулах тухай бодлогын санал зэргийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн;
- Их, дээд сургуулиудын бүтэц, зохион байгуулалт. Экспертийн судалгааны зөвлөмжийг боловсруулж БСШУЯ-нд хүргүүлсэн;
- БНХАУ, ОХУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, ач холбогдол;
- “БНХАУ-ын хөгжилд шинжлэх ухааны салбарын гүйцэтгэж буй үүрэг, инновацийн бодлого, хөгжлийн төлөв” зөвлөмжийг УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн;
- Монголын геополитикийн дэд бүтцийг байгуулах тухай /developing mongolia’s geopolitical infrastructure/ бодлогын зөвлөмжийг монгол, англи хэлээр боловсруулав;
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа;
- Үйлдвэржилтийг дэмжих арга замын тухай;
- Монгол улсын төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой эрх зүйн орчны өнөөгийн байдлын судалгаа;
- Малын гаралтай түүхий эдээс уураг боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл боломж;

- Сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөв, иргэдийн оролцоог үр дүнтэй ашигласан туршлага, сургамж;
- Хөгжлийн урт хугацааны бодлого;
- Ногоон хөгжлийн бодлого зөвлөмжийг боловсруулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн байна
- Говь-Алтай аймгийн хойт сумдын (Бугат, Тонхил, Төгрөг, Шарга, Дарви, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир) нэн ховор, ховор, ашигт ургамлын тархац, нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зөвлөмж.
- Сүхбаатар аймгийн ашигт ургамлын тархац, тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зөвлөмж.
- Ховд аймгийн ашигт ургамлын тархац, тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зэрэг зөвлөмжийг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлсэн байна.

Дэлхийн Өвийн Монголын урьдчилсан жагсаалтыг шинэчлэн боловсруулах төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцон ажиллаж “Буган хөшөө бүхий хүрлийн соёлын цогцолбор дурсгалууд”, “Хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор дурсгалууд”, “Монголын говь нутаг дахь хадны зургийн цогцолбор дурсгалууд” өвийн тодорхойлолтыг холбогдох журмын дагуу боловсруулж Монголын Байгаль, соёлын өвийг хамгаалах санд хүлээлгэн өгөв.

“Үндэсний байгаль, соёлын өв, газар нутгийг тодорхойлох” гэрээт ажлыг БОНХЯ-ны захиалгаар гүйцэтгэж, Хангай, Хэнтийн нурууд, Хөвсгөл нуур орчмын бүс нутгийг улсын нөөцөд авч, байгалийн нөөцийн парк байгуулах эрхзүйн орчныг бүрдүүлэхийг УИХ-д, Үндэсний парк байгуулах ажлыг зохион байгуулахыг МУ-ын Засгийн газарт зөвлөмж болгов.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас санаачлан БОНХЯ, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга зам боломжууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулж, зөвлөмж боловсруулав.







БОНХЯ-ны захиалгаар “Мансууруулах, донтуулах төрлийн ургамлын тархац-нөөц тогтоох” судалгааг гүйцэтгэж, харьцангуй түгээмэл, аймгуудын 57 хувьд тархалттай, мансууруулах, донтуулах үйлдэлтэй 2 зүйл ургамлын тархалт нөөцийг тогтоон, тархалтын цэгийг тэмдэглэн хууль хяналтын холбогдох байгууллагад шилжүүлснээр тухайн ургамлыг хяналтанд авах боломж бүрдэв.

БОНХЯ-ны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, Монгол орны ойн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах, уур амьсгалын дулаарал, хүлэмжийн хийн сөрөг нөлөөллийг сааруулахад төрөөс баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн Монгол орны ойн сангийн өнөөгийн төлөв байдлыг үнэлэх “Олон зорилтот ойн тооллого”-ыг орчин үеийн дэвшилтэт аргазүйн дагуу хийж гүйцэтгэсэн.



Соёлын өвийн тухай Монгол улсын хуулийн дагуу эртний амьтан, ургамлын үйлдвэрийн тархалт, тэдгээрийн хөндөгдөх боломжийг судлан тогтоох ажиллагааг 63 компани, байгууллагын талбай, газарт явуулж, тайлан, дүгнэлт гаргажээ.

Төмөр замын трассын нийт 1800 км урттай талбай газарт эртний амьтан, ургамлын хайгуул судалгааны нэгдүгээр шатны ажлыг гүйцэтгээд байна.

Нийт 19 аймгийн 117 сумын нутаг дэвсгэрийн хүрээнд явуулсан авран хамгаалах хайгуулах явцад 151 талбайгаас 5128 дурсгал шинээр илрүүлэн улсын хамгаалалтанд оруулаад байна.

Хот төлөвлөлт, эрүүл мэнд, дэд бүтэц, байгаль орчин, ногоон хөгжлийн болон мэдээлэл технологийн чиглэлээр нийслэлийн ЗДТГ-тай хамтран ажиллаж, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төвийн баазыг түшиглэсэн Нээлттэй одон орон төсөл хэрэгжүүлж эхлээд байна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн өнгөн хөрсөн дэх хүнд элементүүдийн тархалт, бохирдлын үнэлгээний 1:25000 масштабтай зураглалыг гаргаж, оршин суух экологийн таатай орчин бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлэмжийн зөвлөмж

боловсруулах ажлыг гүйцэтгэв. Туул, Сэлбэ голуудын орчныг сэргээн сайжруулах ТЭЗҮ боловсруулав.

Нийгмийн ухааны салбарын бага чуулганаас Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Яам, Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Монголын Үндэсний Номын Сан, Монгол Судлалыг Дэмжих Сантай хамтран Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч Онходын Жамъян гүний мэндэлсний 150 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулж, Жамъян гүнгийн цуглуулсан ховор нандин түүх шастираар үзэсгэлэн гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр өргөн сурталчиллаа.



Түүхийн хүрээлэнгээс Нийслэлтэй хамтарч Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын 375 жилийн ойд зориулсан “МОНГОЛЫН НИЙСЛЭЛ: НҮҮДЛЭЭС СУУРЬШИЛД” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2014.10.24 өдөр амжилттай зохион байгууллаа.





ССАЖЯ-ны захиалгаар тарбозаврын олдворыг буулгах, олон дахин давтан бэхжүүлэх, сэргээн засварлах, шинээр дэглэх ажлыг гүйцэтгэв.

Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны хөтөлбөрийг дэмжин “Монгол орны байгаль орчин, экологийн өнөөгийн төлөв байдал, нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө” сэдвээр БОНХЯ, УУЯ-тай хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийг ГГЗС-ын Бага чуулганы даргын тушаалаар байгуулан ажиллаж байна.

ШУА-ийн ой судлаач эрдэмтдийг хамруулсан өргөтгөсөн хэлэлцүүлгийг БОАЖЯ дээр зохион байгуулж ойн олон жилийн судалгааны үр дүн төрөөс ойн талаар баримтлах бодлогод тусгалаа олсон болно.

Монгол улсын Их хурлын Тамгын газраас зохион байгуулсан “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд судалгааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэгт “Суурь судалгаа, түүний үр дүнг бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах боломж”-ийн талаар ШУА-ийн байгууллагуудын жишээн дээр илтгэн, хэлэлцүүлж, саналаа хүргүүлэв.

Монгол улсын ШУА нь шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор БОНХЯамтай Монгол орны байгаль орчин, байгалийн нөөц баялгийг хамгаалах биологийн болон генетик нөөцийг зохистой ашиглах, байгалийн баялгийн нөөцийг тогтоох, нөхөн сэргээх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, Монгол улсын нэгдэн орсон олон улсын холбогдох конвенцийн хэрэгжилтийг хангах, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг гэрээний хүрээнд ШУА-ийн Геоэкологи Газарзүй, Биологи, Ботаник, Хими хими технологийн хүрээлэнгийн судлаачид олон арван ажлыг гүйцэтгэлээ. Тухайлбал:

Газарзүйчид Шинэчлэлийн засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хэнтий Хангайн нуруу, Хөвсгөл, Монгол Алтайн нуруу, Хялганат хээрийн байгалийн нөөцийн паркийн үндэслэл боловсруулж, хилийг тогтоох, улмаар хамгаалах статус зохистой ашиглах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар зөвлөмж боловсруулж, захиалагчид хүлээлгэн өгөхөд бэлэн болж байна. Мөн яамны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захиалгаар 1:1000000 масштабтай “Монгол орны мөнхцэвдэгийн тархалтын зураглал” ажлыг гүйцэтгэж байна.

Геоэкологичид тус яамны захиалгаар “Өмнөговь аймгийн говийн баян бүрдүүдийн байршил, төлөв, байдал нөхөн сэргээх боломж”, Баянхонгор аймгийн Бууцагаан, Хүрээмарал сумдын хил залгаа нутагт орших Богд уулыг Улсын тусгай хамгаалалттай газрын “Байгалийн нөөц газар”-ын ангилалд хамруулах үндэслэл, Төв аймгийн Баянцогт, Цээл, Заамар, Сүмбэр сумдын нутагт хээрийн судалгаа явуулж цөлжилт, газрын доройтлын үнэлгээ, “Чойбалсан хотын ногоон байгууламжийн хөнөөлт шавьж түүнээс сэргийлэх арга зам” гэрээт ажлуудыг гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөв. Мөн “Олон зорилтот ойн тооллого”-ын ажлын хүрээнд Төв аймгийн ой бүхий Заамар, Цээл Баянцогт, Жаргалант,





Баянчандмань Борнуур, Батсүмбэр, Эрдэнэ Мөнгөнморьт сумдын ойн тооллогын ажлыг гүйцэтгээд байна.

Биологичид устах аюулд орсон Мазаалай баавгайн хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулахын тулд ангилал зүйн асуудлыг шийдэх, тоо толгойн хэлбэлзэлийг гаргах судалгааны ажлыг гүйцэтгэснээр мазаалай баавгай нь 5000 гаруй жилийн өмнө хүрэн баавгайн зүйлээс салбарласан шинэ дэд зүйл болохыг тогтоосон байна. Мөн Мазаалай баавгайд тохиромжтой амьдрах орчны загварчлал боловсруулж, хамгааллын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Ой Судалгаа Хөгжлийн төвтэй хамтран Баруун бүсийн аймгуудаар ойн хөнөөлт шавжны өвчний голомт тархалтыг илрүүлэх судалгааг хийж тайланг хүлээлгэн өгч, хамтран ажиллаж байна. Түүнчлэн “Төв Дархан, Сэлэнгэ, Булган аймагт тариалсан тосны болон малын тэжээлийн ургамалд шилжмэл ген тодорхойлох” гэрээт ажлыг гүйцэтгэж байна.

Химичид БОНХЯ-ны захиалгаар “Нефть, нефтийн бүтээгдэхүүнийг байгаль орчинд ээлтэй аргаар нөхөн сэргээх технологи” төслийг хэрэгжүүлж, тодорхой объектуудын нефть, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хөрсний агуулга микроорганизмын тоо хэмжээг тодорхойлох, улмаар бохирдсон хөрсөнд янз бүрийн “био” гаралтай субстратуудыг нэмж хөрсний өөрийнх нь ашигтай микроорганизмуудын өсөн үржих нөхцлийг сайжруулах замаар нефтийн бохирдлын хэмжээг бууруулах араг замыг судалж байна. Мөн удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенцийн заалтуудыг Монгол улсад хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хэлэлцүүлэгт удаа дараалан оролцож, тус яамны хөрөнгө оруулалтаар диоксин ба фуран тодорхойлох лабораторийг байгуулж, Полихлорт бифенилийн лабораторийн үйл ажиллагаа өргөжин хөгжиж, албан байгууллагуудын хүсэлтээр олон арван дээжинд шинжилгээ хийж хамтран ажиллаж байна.

Шинжлэх ухаан, боловсролын нягт хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглаж байгаа байгаль шинжлэл, амьгүй байгалийн сурах бичгүүдэд зөвлөмж боловсруулав.

ЕБС-ийн сурагчдын ургамал судлалын онолын мэдлэгийг баталгаажуулахад шаардлагатай дадлагын хичээлийн үзүүлэн таниулах материал, тухайлбал, Монгол оронд өргөн тархалттай 37 овог 140 төрөлд хамаарах 186 зүйл гуурст дээд ургамал, 25 зүйл доод (замаг, мөөг, хаг) ургамлын онцлог шинжийг харуулсан 70 ширхэг зурган үзүүлэн (CD –ийн хамт), 20 гаруй тогтмол препаратыг бэлтгэж өгөх ажлыг санаачилж, төслийг БСШУЯ-нд хүлээлгэн өгөөд байна.



## **ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАЛААР**

Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан томоохон асуудлуудыг судлан шийдвэрлэх, зорилгоор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас санаачлан, хөдөө, орон нутагт тулгамдаж буй асуудлыг эрдэмтдийн оролцоотойгоор шийдвэрлэх, орон нутгийн хөгжилд шинжлэх ухааны оролцоог нэмэгдүүлэх ажлыг 2012 оноос эхлэн хэрэгжүүлж, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Ховд, Баян-Өлгий зэрэг аймгууд болон Нийслэлтэй хамтын ажиллагааны гэрээтэй байгуулан ажиллаж байна.

Гэрээний дагуу аймаг, орон нутгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ховор, ашигт амьтан, ургамлын тархац нөөцийг тогтоох, цөлжилт, бэлчээрийн талхагдал, түүх дурсгалт газрыг хамгаалах, ашиглах болон зарим аймгийн хүн амын хөгжил, эрүүл мэнд, мал аж ахуй, газар тариалан, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон ажлыг жил жилийн төлөвлөгөөндөө тусган гүйцэтгэж байна.

Тухайлбал, Баруун бүс нутагт шинжлэх ухаан, технологийн парк байгуулах, сумын төвийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, ногоон хөгжлийн загвар хотын төсөл хэрэгжүүлэх, Тайшир, Дөргөний усан цахилгаан станцыг түшиглэсэн нар, салхины цахилгаан станц байгуулах төсөл боловсруулах, утаагүй түлш үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх, аймгийн нэгдсэн атлас зохиох зэрэг нилээд ажлыг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

Манай эрдэмтэд Монголын Архитекторын Эвлэлтэй хамтран Ховд аймгийн Дөргөн, Манхан сумдын “Сумын төвийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж, Ховд Их сургуулийн эрдэмтэдтэй хамтран Ховд аймгийн нэгдсэн атлас боловсруулах ажлыг гүйцэтгэж, хэвлэлийн эхийг хүлээлгэн өгөөд байна.





Говь-Алтай аймгийн Тайшир, Ховд аймгийн Дөргөний Усан цахилгаан станцыг дэмжихээр тус бүр 10000 кВт-ын хүчин чадал бүхий нарны цахилгаан станц байгуулах төсөл боловсруулаад одоо хэрэгжүүлэх талаар ажиллаж байна.

Завхан аймгийн ЗДТГазартай ШУА-ийн байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд тус аймагт экосистемийн судалгаа явуулах ажлыг санаачлан ШУА-ийн Ботаникийн хүрээлэнг Монгол Оросын хамтарсан иж бүрэн экспедицтэй хамтран тусгайлсан гурвалсан гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав. Гэрээний хүрээнд 2014 онд Тосонцэнгэл, Их уул, Дөрвөлжин, Яруу сумдад МОХБИБЭ-тэй хамтарсан судалгааны отрядыг ажиллуулж экосистемийн судалгааны ажлыг орон нутгийн төсвийн хүрээнд хийж гүйцэтгэв. Түүнчлэн 2015-2017 онд хэрэгжүүлэх судалгааны ажлын хөтөлбөрийг боловсруулан хүргүүлж, төсвийг 2015 оны Завхан аймгийн хөгжлийн төсөвт суулгуулж батлуулав.

Говь-Алтай аймагтай хамтран “Засагт хан аймгийн түүхийн судалгаа баримт, хээрийн шинжилгээ” төслийг хэрэгжүүлж байна.

“Баянхонгор аймгийн гадаргуу, гүний ус, рашаан усны иж бүрэн судалгаа” төслийг хэрэгжүүлж, 20 гаруй сумын 480 орчим уст цэгийг судалсны үндсэн дээр Баянхонгор аймгийн гидрохимийн зураглалыг боловсруулж захиалагчид нь хүлээлгэн өгөв.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас 2014 оныг “Чанарыг дээшлүүлэх, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулах жил” болгон зарласантай холбогдуулан манай эрдэмтэд “Баялаг-Эрдэнэ цом” ХХК-тай хамтран өдөрт 20 тн утаагүй түлш хагас коксон-шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг Говьсүмбэр аймгийн Чойрт байгуулан, бүтээгдэхүүнээ Улаанбаатарын хэрэглэгчдэд нийлүүлж эхлээд байна.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын дунд сургуулийн хичээлийн байрыг газрын гүний дулааныг ашиглан халаах төслийг хэрэгжүүлэхээр орон нутгийн байгууллагуудтай тохиролцон, төсөлд шаардлагтай хээрийн судалгааны ажлыг гүйцэтгээд байна.

Хөвсгөл нуур орчмын жуулчны баазуудын ахуйн хаягдал бохир усыг цэвэршүүлэх, хөрсийг эрүүлжүүлэх ажлыг Япон улсын судлаачидтай хамтран хийж гүйцэтгэв.

Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Ерөнхийлөгч академич Б.Энхтүвшин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл нар 2 дугаар сарын 20-ны өдөр хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсны дагуу 2014-2016 онуудад шинжлэх ухааны байгууллага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүтээлч, нягт хамтын ажиллагааг өргөжүүлэх, Улаанбаатар хотыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаар болж, хоёр тал хот төлөвлөлт, байгаль орчин ногоон хөгжил, эрүүл мэнд, дэд бүтэц, мэдээлэл технологи, Нээлттэй одон орон хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллаж эхлээд байна.



Нийслэлийн удирдлагуудын зүгээс Улаанбаатар хотын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжит арга замуудыг тодорхойлоход эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлэх, дэмжиж ажиллах, шинжлэх ухаан, технологийн болон хөгжлийн төсөл захиалах, судалгаа болон туршилтын ажилд хамтран ажиллах хүсэлтэй байгаа ба нийслэлийн хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтын томоохон төслүүдэд эрдэмтэн судлаачдын багийг татан оролцуулах, хот төлөвлөлт, судалгааны хүрээлэнг сэргээн байгуулж, ШУА-ийн харьяанд ажиллуулах саналыг Монгол улсын Засгийн газарт хамтран уламжлахаар ажиллаж байна.

Булган аймгийн Хялганат тосгоны Хайлантын ам дахь ойн суурингийн мод үржүүлгийн газарт 15000 ш нарсны тарьц ургуулан “Хайлантын ам”-ны түймэрт нэрвэгдсэн хусан ойн 5 га талбайг нарсны 2 настай 12500 ширхэг тарьцаар ойжуулав.

Өмнөх онд боловсруулсан ойн түймэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах аргачлалыг ойн аж ахуйд нэвртүүлж, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ аймгийн нутгуудад (200 км урт 10 м өргөнтэй 40 см гүн) ойн түймэрээс сэргийлэх, хамгаалах зурвасыг байгуулан БОНХЯам-д хүлээлгэн өгөв.

Баянхонгор аймгийн Баянлиг сумын “Ламын гэгээний хурдан хүрэн”, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Галбын говийн улаан, Мандал-Овоо сумын Ханын хэцийн хүрэн, Говь-Алтай аймгийн Төгрөг, Тонхил сумын Хос зогдорт зэрэг монгол тэмээний омог, үүлдрийн хэсгийн популяцийн генетикийн судалгаагаар монгол тэмээний популяци доторх хувьсал нилээд өндөр байгаа буюу популяцийн генетик алслалт үүлдрийн төвшинд хүрээд байгааг илрүүлж, үүлдрийн тодорхойлолтыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлэв.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын хөндийд Усан цахилгаан станц шинээр барих талбайд явуулсан археологийн авран хамгаалах судалгааны дүнд Чулуун зэвсгийн үеийн бууц суурин, Хүрлийн болон Хүннүгийн үеийн булш нийт 44 дурсгалыг авран хамгаалсан байна.

Уул уурхай болон дэд бүтцийн 19 компани, байгууллагын 23 талбайд палеонтологийн хайгуул судалгаа зохион явуулж, дүгнэлт, ажлын тайланг холбогдох байгууллагад нь хүлээлгэн өгөв.

“Төмөр зам” төслийн талбайд палеонтологийн судалгааг Өмнөговь аймгийн “Ухаа худаг-Гашуун сухайт”, “Цогтцэций—Манлай—Сайншанд—Баруун-урт” болон “Баруун-Урт – Хөөт, Хөөт - Чойбалсан – Эрээнцав, Хөөт – Бичигт” 3 чиглэлийн дагуу явуулж, тайланг захиалагчид нь албан ёсоор хүлээлгэн өглөө.

## **НОМЫН АЯН - 3**

Шинжлэх ухааныг сурталчлах түгээн дэлгэрүүлэх, номын өв санг арвижуулах, хүүхэд залуучуудын боловсролд оюуны хөрөнгө оруулалт хийх зорилгоор ШУА-ийн эрдэмтэн

судлаачдын туурвисан бүтээлийн дээжээс энэ онд хамгийн идэвх санаачилгатай хамтран ажилласан аймаг, орон нутгийн номын сан, ЕБС-иудад хандивлах “НОМЫН АЯН 3” үйл ажиллагааг уламжлал болгон амжилттай зохион байгууллаа.

“Ном бол оюун санааны тусгаар тогтнол” уриан дор зохион байгуулагдсан “Номын баяр”-ын ном хандивлах аяны хүрээнд 10 сая гаруй төгрөгийн үнэ бүхий 900 орчим ном, нэгэн сэдэвт бүтээлийг 3 удаагийн арга хэмжээгээр Завхан, Говь-Алтай, Сэлэнгэ, Ховд, Баянхонгор, Архангай зэрэг нийт 6 аймгийн нийтийн номын сангуудад гардуулан өглөө.







## ИХ ДЭЭД СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАЛААР

ШУА-ийн хүрээлэн, төвүүд нь улсын хийгээд хувийн хэвшлийн сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, өөрийн мэргэжлийн чиглэлээр бакалавр, магистр болон докторын сургалтад хичээл заах, бакалавр, магистр, докторын ажил удирдаж хамгаалуулах, оюутны үйлдвэрийн болон танилцах дадлага удирдах, их дээд сургуулиудын эрдмийн зөвлөлд орж ажиллах, сургалтын хөтөлбөр боловсруулах болон сурах бичиг, гарын авлага бэлтгэх, хянан тохиолдуулах, үндэсний хэмжээний болон олон улсын эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулах зэрэг хэлбэрээр хамтран ажиллаж байна.

МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургууль, МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургууль, ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургуультай хамтран “Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.

МУБИС, МУИС, ШУТИС-ийн бага чуулганд сууж буй гишүүдийн оролцоотой “Судалгааны ажлын үр өгөөжийг дээшлүүлье, чанарыг сайжруульъя” сэдэвт ярилцлага-хэлэлцүүлэгийг зохион байгуулж, суурь судалгааны сэдэвт ажил боловсруулах, тайлан бичихэд стандартыг хангуулах ажлыг зохион байгуулав. МУИС, МУБИС-тай Хүрээлэнгүүд хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж, магистрант, докторантуудын сургалт, дадлагын ажилд хамтран оролцож байна.

МУИС-ийн ФЭС болон ШУТИС-ийн Материал судлалын сургуультай хамтран “Материал судлал” (Material Science) сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний ээлжит III бага хурлыг зохион байгуулав.

Их дээд сургуулиуд, төрийн болон төрийн бус байгууллагууд, Монголын Физикийн Нийгэмлэг, аж ахуйн нэгж, хувийн сектор болон гадаадад ажиллаж сурч буй физикчидтэй хамтран “ФИЗИКЧДИЙН ҮНДЭСНИЙ II ФОРУМ”-ыг зохион байгуулав.

ШУА-ийн Физик технологийн хүрээлэнгээс физикчдийн залуу халааг бэлтгэх, байгалийн шинжлэх ухаанаар суралцагч оюутан залуусыг хөхүүлэн дэмжих, их дээд сургуультай хамтран ажиллах бодит шаардлагыг хангах зорилгоор цалинтай оюутан хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.

Монголын Үндэсний Их сургуультай хамтран ажиллаж, Сургалт шинжлэх ухаан үйлдвэрлэл, инновацийг хамтран хөгжүүлэх зорилгоор “Инноваци” сэтгүүлийг 2015 оноос хамтран гаргахаар бэлтгэл ажлыг зохион байгуулав.

Отгонтэнгэр Их Сургууль, Идэр дээд сургуультай хамтран “Монгол улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм



шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. Тус хурал “Эдийн засаг”, “Улс төр, нийгэм, ёс суртахуун” гэсэн салбар хуралдаанаар явагдаж, эрдэмтдийн дэвшүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэн УИХ, Засгийн газарт уламжлав.

Дорнод аймагт болсон “Орон нутгийн их, дээд сургуулиудын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, орон нутгийн их, дээд сургуультай хамтран ажиллах саналыг дэвшүүлэв.



## ИХ ЧУУЛГАН

---

ШУА-ийн Их чуулган 2014 оны 2 дугаар сарын 14-нд хуралдаж, ШУА-ийн 2013 оны эрдэм шинжилгээ үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, ШУА-ийн гишүүний сонгуулийг явуулав.

Академийн гишүүний сонгуулийн зарыг Өдрийн сонины 2013 оны 12 дугаар сарын 10-ны 297 дугаарт нийтэлж олон нийтэд хүргэв.

Энэ удаагийн сонгуульд эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудаас 41 эрдэмтний нэрийг дэвшүүлж, материал ирүүлснээс академийн төрөлжсөн академиуд болон салбарын бага чуулгануудаас 16 эрдэмтнийг нууц санал хураалтаар шалгаруулан ШУА-ийн гишүүнд нэр дэвшүүлсэн байна.

Эдгээр 16 эрдэмтнээс академийн гишүүдийн 75 болон түүнээс дээш хувийн санал авсан Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор Н.Бэгз, Шинжлэх ухаан технологийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, доктор Т.Ган-Эрдэнэ, ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, доктор Ч.Доржсүрэн, ХААИС-ийн Мал эмнэлгийн хүрээлэнгийн төслийн удирдагч, доктор Ш.Дэмбэрэл нар ШУА-ийн гишүүнээр сонгогдов.

2014 оны байдлаар академийн гишүүдийн тоо 62, нийт гишүүдийн 42 хувь нь ШУА-ийн харьяа хүрээлэн, төвд, 34 нь буюу 21 гишүүн их, дээд сургуульд, 24 хувь нь буюу 15 гишүүн нь бусад байгууллагад ажиллаж байна.





## БАГА ЧУУЛГАН

---

Салбарын бага чуулганы гишүүнийг сонгох мэргэжлийн чиглэл, тоог Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн тогтоож, батлагдсан мэргэжлийн чиглэл, тоог өдөр тутмын хэвлэлд нийтэлж, сонгуульд салбар салбарын шилдэг эрдэмтдийг оролцох боломжоор хангав.

Энэ удаагийн ротациар салбарын бага чуулганы гишүүнээр 30 хүн шинээр сонгогдов. 2014 оны байдлаар ШУА-ийн салбарын бага чуулган болон төрөлжсөн академиуд нь нийт 231 гишүүн, тэдний 33 хувь нь ШУА-ийн харьяа хүрээлэн, төвд, 39 хувь нь их, дээд сургуульд, 19 хувь нь бусад байгууллагад ажиллаж байгаа бол төрийн төлөөлөлөөр 20 гишүүн сонгогдон ажиллаж байна.

Салбарын бага чуулганууд нийт 22 удаа хуралдаж дууссан шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажлын тайлан хэлэлцэх, зөвлөмж батлах, шинээр сэдэв, төсөл дэвшүүлэх, Бага чуулганы гишүүдийн нөхөн сонгууль, Бага чуулганы даргын сонгууль, ШУА-ийн Их чуулганы гишүүнд нэр дэвшүүлэх, МУ-ын Төрийн шагналд нэр дэвшүүлэх болон цаг үеийн бусад асуудлуудыг тухай бүр нь авч хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

2013 онд хэрэгжиж дууссан 56 суурь судалгааны сэдэвт ажлын тайланд холбогдох салбарын бага чуулганаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, захиалагчид шилжүүлсэн байна.

Салбарын бага чуулгануудаас 2015 оноос эхлэн хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн суурь судалгааны 55 сэдэвт ажлын саналыг БШУЯ-нд хүргүүлэв.



## БИОЛОГИЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН

### *Бага чуулганы өнөөгийн бүтэц*

Бага чуулганы гишүүний 30 хүртэл хувийг 2 жил тутамд шинэчилнэ гэсэн Бага чуулганы дүрмэнд тусгагдсан заалтийн хүрээнд 2014 оны 3 сард нөхөн сонгууль явуулж, бага чуулганы шинэ бүтцийг бий болгосон. Нөхөн сонгуульд хүрээлэн төв, Их дээд сургууль зэрэг байгууллагуудаас нийт 14 хүн нэр дэвшсэнээс сонгуулиар 6 хүн бага чуулганы гишүүнээр сонгогдсон юм. Өнөөдөр 24 гишүүнтэй, үүнээс Их, дээд сургуулийн төлөөлөл-5, Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл-4, гадаад оронд ажилладаг монгол эрдэмтэн -1 байгаа нь бага чуулганы гишүүний 41 %-ийг бүрдүүлж байна.

Бага чуулганы гишүүнээр МИУС-ын ШУ-ны сургуулийн Байгалийн ухааны салбарын Биологийн тэнхимийн, МУ-ын Боловсролын их сургуулийн Математик байгалийн ухааны сургуулийн, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв-ийн багш нар сонгогдон бага чуулганы үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна. Ингэж бага чуулганы бүтэц олон талт байгууллагын гишүүнчлэлээс бүрдэж байгаа нь биологийн шинжлэх ухааны салбарын хүрээнд нэгдмэл үйл ажиллагаатай нэгдсэн бодлого барин ажиллах боломжийг бүрдүүлж байдаг.

### *2014 онд хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудал*

Энэ онд 5 удаа хуралдаж дараах асуудлыг шийдвэрлүүлэв. Үүнд:

Бага чуулганы гишүүдийн 30%-ийн шинэчлэлийг хийж, нөхөн сонгууль явуулав.

ШУА-ийн жинхэнэ гишүүнд нэр дэвшигчдийн сонгуулийг зохион байгуулж, доктор Ч.Доржсүрэн ШУА-ийн гишүүнээр сонгогдов.

2011-2013 онд биологийн салбарын Биологийн хүрээлэнд-9, Ботаникийн хүрээлэнд -3, Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төвд-1, МУИС-ийн ББТ-ийн сургуульд-1, ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнд-1, нийт хэрэгжиж дууссан 15 суурь судалгааны сэдвийн гүйцэтгэлийн тайланд мэргэжлийн эрдэмтдээр эксперт хийлгүүлж, бага чуулганаар хэлэлцүүлэн, хүлээн авсан тайланг, дүгнэлтийн хамт холбогдох газарт шилжүүлэв.

2015-2017 онд шинээр хэрэгжүүлэхээр ШУА-ийн Ботаникийн хүрээлэн, МУИС-ийн ББТ-ийн сургууль, МУБИС-ын Байгалийн ухааны сургууль зэрэг байгууллагуудаас дэвшүүлсэн 6 суурь судалгааны сэдвийг хэлэлцүүлж, шийдвэрийг БШУЯ-ны Шинжлэх Ухаан технологийн газарт хүргүүлэв.

Салбарын хүрээнд тодорхой шинжлэх ухааны салбарын ололт, дутагдлыг шүүн



хэлэлцэх ажлын хүрээнд ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн Ургамлын физиологийн салбарын эрдэмтэд “Ургамлын физиологийн шинжлэх ухааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” хэлэлцүүлгийг бага чуулганд зохион байгуулж, өнөөгийн хүрсэн түвшинг тогтоож, цаашдын чиг баримжаа, зорилгоо тодорхойлж, лабораторийн материаллаг баазыг сайжруулах, орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай байгаа тухай боловсруулсан төсөл, саналыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт оруулахаар бэлтгэж байна.

***Засгийн газар болон бусад байгууллагад хүргүүлсэн зөвлөмж, бодлогын баримт бичигт тусгуулсан асуудлын талаар:***

Монгол орны ойн санг орчин үеийн дэвшилтэт аргаар тоолох “Олон зорилгот ойн тооллогын гарын авлага” боловсруулах ажилд хамтран оролцож ойн тооллогыг явууллаа. Түүнчлэн “Ой зохион байгуулалтын ажлын технологийн аргачлал”-ыг боловсруулан хүлээлгэн өгөв.

2014 оны бага чуулганы төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд бага чуулганы гишүүн БОНХАЖЯ-ны хэлтсийн дарга, доктор Ц.Банзрагч хариуцан хамтарсан хэлэлцүүлэгүүдийг удаа дараа зохион байгуулсан юм. Уг хэлэлцүүлэгийн хүрээнд манай ой судлаач эрдэмтдийн гаргасан саналууд УИХ-д өргөн барьсан “Ойн талаар төрөөс баримтлах бодлого” баримт бичигт тусгагдаад байгаа юм.

2013 онд “Монголын улаан ном”-д орсон монгол улсад цөөхөн тоотой үлдээд байгаа “Мазаалай баавгайг хамгаалах” асуудлаар БОХХААБХ-д хэлэлцүүлэг зохион байгуулж Байнгын хорооны тогтоол гаргуулан ажилласны дүнд 2014 онд БОНХАЖЯ-ны зардлаар АНУ-ын Айдохигийн их сургуульд манай судлаач ажиллан мазаалай баавгайн ангиллзүйн асуудлыг шийдвэрлэж, мазаалай баавгай ( *Ursus arctos gobiensis*) нь 5000 гаруй жилийн өмнө хүрэн баавгай (*Ursus arctos*)-н зүйлээс салбарласан шинэ дэд зүйл болохыг тогтоогоод байна. Энэ нь цаашид түүний хамгаалах асуудалд чухал шийдвэрлэх алхам болох ач холбогдолтой болов.

Монгол Улсын засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 277 –р тогтоолд “Цөөвөр чоно, соргог бөхөнг сэргээн өсгөх боломжийг тогтоох, арга технологи боловсруулах” төсөл хэрэгжүүлж ажиллахыг БОАЖЯ-ны болон БСШУ-ны сайд нарт даалгасан юм. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор БОНХСайдын 2013 оны 03 сарын 18-ны өдрийн А/76 тоот тушаалаар “Соргог бөхөн улаан чоныг сэргээн өсгөх боломжийг тогтоох судалгаа”-г явуулж, дүн шинжилгээ хийсний дүнд Монголд соргог бөхөн, улаан чоно устсан ба сэргээн нутагшуулах нөхцөл, боломж байхгүй болохыг тогтоосон дүгнэлт, саналыг боловсруулан захиалагч – БОНХАЖЯ-д хүлээлгэн өгөв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 3-р сарын 29-ний өдрийн зарлигт тусгагдсан Хөвсгөлийн тайгад амьдарч буй цаатан иргэдийн амьдралыг дээшлүүлэх, тэдний боловсрол нийгмийн хамгааллыг сайжруулах ажлын чиглэлд “Цаа бугын зүй бус



хорогдлыг бууруулах үүднээс тусгай хамгаалалттай газар нутагт чонын болон булганы ав зохион байгуулахтай холбогдсон харилцааг Амьтны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх” гэж тусгагдсан. БОНХЯ-ны захиалгат ажлын хүрээнд ойн булганы тархац, байршил нөөцийг тогтоох судалгааг хийж, Тэнгис Шишгэдийн БЦГ, түүний орчны бүс нутагт 1000 га-д дунджаар 1,7 толгой ноогдох нягтшилтай 4580,2 км<sup>2</sup> нутагт 3478±174 ойн булгатай болохыг тогтоосноор тус бүсд булганы агнуурын үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болохыг тогтоосон зөвлөмж саналыг боловсруулан захиалагчид хүргүүлэв.

### ***Зөвлөмжүүд:***

Орон нутгийн БОГазарт Говь-Алтай аймгийн хойт сумдын Бугат, Тонхил, Төгрөг, Шарга, Дарви, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир сумдын нэн ховор, ховор, ашигт ургамлын тархац, нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зөвлөмж.

Сүхбаатар аймгийн ашигт ургамлын тархац, тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зөвлөмж. Аймгийн БОГазарт.

Ховд аймгийн ашигт ургамлын тархац, тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зөвлөмж. Аймгийн БОГазарт.

### ***Шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр:***

Шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн боловсролын газартай хамтран ЕБС-иудад лекц хийх ажлыг ШУА-ын тэргүүлэгчдийн газар зохион байгуулсан бөгөөд үүний хүрээнд Биологийн салбарын эрдэмтэн доктор Х.Түмэннасан “Генетикийн гайхамшиг” сэдэвт лекцийг Эрдмийн ундраа цогцолборын багш, сурагчдад хийв.

Биологийн баларын хүрээнд судалгааны ажлын үр дүн, явцын талаар сурталчлах ажлыг зохион байгуулж танин мэдэхүйн хялбаршуулсан нийтлэл-8, өдөр дутмын сонин сэтгүүлд-10, радио 12, TV-35, сургалт сурталчилгаа- 21 удаа хийж, үзэсгэлэнд 6 удаа оролцож танилцуулга хийсэн байна.



## ГЕОЛОГИ ГАЗАРЗҮЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН

### *Бага чуулганы бүтэц, бүрэлдэхүүн*

Тайлангийн хугацаанд Бага чуулганы нөхөн сонгуулийг явуулж, нийт 16 мэргэжлийн чиглэл бүхий 23 гишүүнтэй болж, бүрэлдэхүүнд нь Төрийн байгууллагаас 4, Их дээд сургуулиас 3, салбарын эрдэм шинжилгээний байгууллагаас 1 төлөөлөл, хувийн хэвшлийн 1 төлөөлөл, ШУА-ийн 14 төлөөлөлтэй болж, гишүүдийн 40 хувийг их, дээд сургууль, бусад байгууллагын төлөөлөл эзэлж байна.

Одоо Бага чуулган 5 академич, 1 шинжлэх ухааны доктор, 17 (Ph.D) докторын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

### *2014 онд хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудал*

Тайлангийн хугацаанд Бага чуулганыг 5 удаа хуралдуулж, Бага чуулганы 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын төлөвлөгөөний биелэлт, товч тайлан, 2014 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, Геологи газарзүйн салбарын хүрээлэн, төвд хэрэгжиж дууссан 5 сэдэвт ажлын тайлан, салбарын хүрээлэн төвд 2015 оноос эхлэн хэрэгжих 6 суурь судалгааны сэдэвт ажлын санал, салбараас ШУА-ийн гишүүнд нэр дэвшигчийн мэргэжлийн чиглэлийг тогтоох, академийн гишүүнд нэр дэвшигчийг шалгаруулах, Бага чуулганы гишүүдийн нөхөн сонгууль, МУ-ын Төрийн соёрхолд нэр дэвшүүлэх зэрэг асуудлыг хэлэлцсэн байна.

Бага чуулган “Эрдэм боловсролтой монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Их дээд сургуультай хамтран ажиллах чиглэлээр уулзалт, ярилцлагыг 5-р сард зохион байгуулж, МУИС, ШУТИС, МУБИС, ХААИС-ийн геологи, газарзүй, экологийн чиглэлийн сургалт явуулдаг багш, профессорууд оролцож, цаашид хамтран ажиллах санал бодлоо солилцов. Одоо манай салбарын 43 эрдэмтэн МУИС-ийн Геологи, газарзүйн сургууль, МУБИС, УБИС, ХААИС, Газарчин дээд сургууль, Эко-Ази дээд сургуулиудад өөрийн эзэмшсэн мэргэжил, судалдаг сэдвийнхээ дагуу докторын болон магистрын нарийн мэргэжлийн хичээлүүдийг зааж, дипломын ажлыг нь удирдаж байгаа ба үүнийг улам өргөжүүлэхээр боллоо.

Газрын харилцаа, геодези зурагзүйн газартай хамтран ажиллах зорилгоор хамтарсан уулзалтыг зохион байгуулж, тус байгууллагын мэргэжилтнүүдийг аргагүй, аргачлалаар хангах, улмаар сургалт зохион байгуулахаар Бага чуулган санаачлан ажиллаж байна.

Засгийн газрын (2012-2016) “Эрдэм боловсролтой монгол хүн” хөтөлбөрийг дэмжих үүднээс, Ерөнхий боловсролын сургуульд ашиглах ГМС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад туслан, зөвлөмж боловсруулав. Мөн “Эх хэл” сэтгүүлд дунд сургуулийн хичээл сургалтанд зориулж, холбогдох хэд хэдэн гол чиглэлээр улсын хэмжээний үлгэр



жишээч сурах бичиг бүтээх талаар санал үндэслэл гаргаж, нийтлэл хэвлүүлэв.

Улаанбаатар хотын барилгажилттай холбоотойгоор геотехник, инженерийн цэвдгийн шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж боловсруулж, Нийслэлийн төр, захиргааны газарт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.

### ***Шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх талаар:***

Тус Бага чуулган 2014 онд Шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх ба сурталчилах ажлыг тогтмолжуулахыг нэн тэргүүний зорилт болгон тавьж ажиллалаа.

Шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг тогтмолжуулахын тулд салбарын хүрээлэн, төв тусгай төлөвлөгөө гарган ажиллаж, Газарзүй, Геоэкологийн хүрээлэнгүүд Эко телевизтэй гэрээ байгуулан ажиллалаа. Манай салбарын хүрээлэн, төв телевизийн сувгуудаар 30 удаагийн ярилцлагыг өгч, өдөр тутмын хэвлэлд 19, мэдээ сэтгүүлд 6, эрдэм сонинд 10, мэргэжлийн сурталчилгааны сэтгүүлд 10 нийтлэлийг хэвлүүлж, нийт 70 гаруй мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр сурталчилсан нь өнгөрсөн оныхоос бараг нэг дахин илүү үзүүлэлт боллоо.

Улаанбаатар хотын хөрсний бохирдол сэдвээр Улаанбаатар хотын төв номын санд лекц уншуулж, 60 гаруй хүн оролцож, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав. Мөн геоэкологийн хүрээлэнгийн залуу судлаачид GEOECO клубийг ажиллуулж, сар бүр нэг залуу судлаач судалгааныхаа ажлыг танилцуулж, сурталчилдаг уламжлал тогтлоо.

“Монголын гайхамшигт үлэг гүрвэлүүд” үзэсгэлэнг Японы Нагоя, Кумамото хотуудад гаргаж эх орноо сурталчилснаас гадна, “Өмнөговь аймгаас олдсон палеонтологийн олдворууд”, “мезозойн болон палеозойн амьтан, ургамал”, “үлэг гүрвэлийн өндөг”, “хөхтөн амьтны судалгаа” сэдвээр бэсрэг үзэсгэлэн, “Монгол орны геологи, ашигт малтмалын хайгуул-2014” хурлын үйл ажиллагааны үед “мезозойн болон палеозойн амьтан, ургамал”, “үлэг гүрвэлийн өндөг”, “хөхтөн амьтны судалгаа” сэдвүүдээр ханын самбар хийж, амьтан, ургамал, геологийн чулуулгийн дээжээр бэсрэг үзэсгэлэн гаргаж сурталчилсан байна. Газарзүйчид Герман улстай хамтарсан судалгаа явуулсны 20 жилийн ой тохиож байгааг тохиолдуулан Улаанбаатар дахь ХБНГУ-ын элчин сайдын яамтай хамтран “Монгол Улс, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон 40 жилд Гео-шинжлэх ухааны салбар дахь 20 жилийн хамтын ажиллагаа” үзэсгэлэнг ХБНГУ-ын элчин сайдын яаман дээр зохион байгууллаа.

Палеонтологичид танин мэдэхүйн 3 ном хэвлүүлж, Монголд палеонтологийн салбар үүсэн хөгжсөн түүхэн ойд зориулан “Цаг хугацаагаар аялсан нь” баримтат кино бүтээж, “Монголоос олдсон үлэг гүрвэл /Dinosaurs from Mongolia/” зурагт нэвтэрхий толь - гэрэл зургийн цомгийг бэлтгэн тайлбар танилцуулгыг монгол, англи хэл дээр хэвлүүлсэн нь БШУЯ-ны 2014 оны «Шилдэг бүтээл»-ээр шагнагдсан байна.



## ФИЗИК МАТЕМАТИК ХИМИЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН

### *Бага чуулганы бүтэц, бүрэлдэхүүн*

Тайлангийн хугацаанд Бага чуулганы нөхөн сонгуулийг явуулж, нийт 33 гишүүнтэй болж, бүрэлдэхүүнд нь Төрийн байгууллагаас 2, Их дээд сургуулиас 7, бусад байгууллагаас 2 төлөөлөл, ШУА-ийн 22 төлөөлөлтэй болж, гишүүдийн 33,3 хувийг гадны байгууллагын төлөөлөл эзэлж байна.

### *2014 онд хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудал*

ФМХСалбарын бага чуулган эрдэм шинжилгээ-үйл ажиллагааны 2013 оны тайлан, 2014 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, удирдлага болгон ажиллаа.

Бага чуулганы нийт 6 удаагийн хуралдааныг зохион байгуулав.

ШУА-ийн гишүүний сонгуульд нэр дэвшигчдийг Бага чуулганаар хэлэлцэн, Их чуулганы гишүүний сонгуульд нэг нэр дэвшигчийг оролцуулав.

Салбарын хүрээлэн, төвийн захирлуудын 2013 оны үр дүнгийн гэрээний тайланг нэгтгэн гаргав.

Бага чуулганы даргын сонгуулийг явуулж, Бага чуулганы дарга, орлогч дарга нар шинэчлэгдэв. Бага чуулганы даргаар академич Ж.Тэмүүжин, орлогч даргаар академич Т.Жанлав, академич Р.Тогоо нар сонгогдов.

Захирлуудын сонгон шалгаруулалтанд салбарын хүрээлэн төвийн захиралд нэр дэвшигчдийг зохион байгуулж оролцуулав. Салбарын хүрээнд Информатик, Одон орон геофизик судалгааны төв, Физик технологийн хүрээлэнгийн захирлууд шинээр сонгогдов.

Шинээр сонгогдсон захирлуудын мөрийн хөтөлбөрийг хамт олонд нь танилцуулах ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулав.

Салбарын хүрээлэн, төвд 2013 онд хэрэгжиж дууссан суурь судалгааны 29 сэдэвт ажлын тайланг бага чуулганаар хэлэлцүүлэн, захиалагчид шилжүүлэх ажлыг зохион байгуулав.

Салбарын хүрээлэн төвд 2015 онд шинээр хэрэгжүүлж эхлэх суурь судалгааны 30 сэдвийг бага чуулганаар хэлэлцүүлж 24 сэдэвт ажлыг батлан холбогдох газарт хүргүүлэв.

ФМХ салбарын бага чуулганаас санаачлан Бага чуулганы гишүүд болон эрдэм





шинжилгээний дуусгавар тайлан уншиж саналаа өгч буй судлаачдад ажлын хөлс өгдөг болох талаар санал боловсруулан БШУЯ болон ШУТ-ийн санд хүргүүллээ.

***Шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх талаар:***

Импакт фактор өндөртэй сэтгүүлүүд, судалгааны ажлыг үнэлэх үнэлгээ, шалгуур үзүүлэлтүүдийн талаар Бага чуулганы дарга, академич Ж.Тэмүүжин залуу судлаачдад зориулан лекц уншив.





## ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН

### *Бага чуулганы бүтэц, бүрэлдэхүүн*

Тайлангийн хугацаанд Бага чуулганы нөхөн сонгуулийг явуулж, нийт 10 мэргэжлийн чиглэл бүхий 30 гишүүнтэй болж, бүрэлдэхүүнд нь ШУА-аас 5, Төрийн байгууллагаас 5, Их дээд сургуулиас 11, салбарын эрдэм шинжилгээний байгууллагаас 9 төлөөлөлтэй болж, гишүүдийн 83 хувийг гадны байгууллагын төлөөлөл эзэлж байна.

Одоо бага чуулган 5 академич, 9 доктор (Sc.D), 21 доктор (Ph.D)-ын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

### *2014 онд хэлэлцэж шийдвэрлэсэн асуудал*

Техник, технологийн салбар нь ШУА-ийн Техник, технологийн салбарын бага чуулганы хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулан зохион байгуулж ирсэн болно. Техник, технологийн салбарын бага чуулган нь туршилт судалгаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн боловсруулсан шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил, шинэ техник-технологи, бусад эрдэм шинжилгээний бүтээлийг хэлэлцэж дүгнэлт гаргах, тэдэнд туслах ажлыг эрхлэн ажиллав.

Тайлангийн хугацаанд Бага чуулганыг 4 удаа хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцэв.

- Бага чуулганы бүтэц, ротаци хийх, чуулганы гишүүн сонгох тухай
- Бага чуулгааны даргын сонгууль явуулах тухай.
- Монгол Улсын ШУА-ийн гишүүнд нэрээ дэвшүүлсэн эрдэмтдийн бүтээлийг хэлэлцэж ШУА-ийн Их чуулганд оруулахаар нэр дэвшүүлэх тухай.
- 2015 оноос эхлэн хэрэгжүүлэхээр санал болгож байгаа суурь судалгааны сэдвүүдийг хэлэлцэж дүгнэлт гаргах (4 санал ирсэн)
- Суурь судалгааны сэдвийн болон шинжлэх ухаан, технологийн төсөлт ажлын тайланг хэлэлцэх
- ШУА-ийн ТТСБЧ-ны 2014 оны ажлын тайлан

ШУА-ийн Техник, технологийн салбарын бага чуулганаас санаачлан БОНХЯам, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэл, ШУТИС-ийн холбогдох хүрээлэн, сургууль, Цаг уурын хүрээлэн, инженерүүдтэй хамтарсан “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга зам боломжууд” эрдэм шинжилгээний хурал хэлэлцүүлгийг 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулав.

- Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Байгаль орчин ногоон хөгжлийн



ям, Улаанбаатар хотын захиргаанаас хэрэгжүүлж байгаа Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бодлогод нь зөвлөмж болгох;

- Улаанбаатарын утаатай тэмцэх зөв аргыг шийдлийг тодорхойлоход туслах;
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажилладаг эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачид, компаниудын анхаарлыг энэ асуудалд хандуулах зорилгоор хурлыг зохион байгуулж, 100 гаруй хүн оролцож 11 илтгэл хэлэлцүүлэгдсэн байна.

Хурлын талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өргөн цар хүрээнд мэдээлэгдсэн.

### ***Эрдэм шинжилгээний хурал-хэлэлцүүлэг нь:***

- Агаарын бохирдлыг бууруулах эрчим хүчний технологийн үр ашгийг дээшлүүлэх
- Шинэ технологи, дэвшилтэт арга
- Нийслэлийн агаарын бохирдлын төлөв байдал

гэсэн үндсэн 3 чиглэлээр явагдсан бөгөөд эдгээр үндсэн асуудлуудын хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлын шалтгаан, төлөв байдал, хор уршиг, нийгэм эдийн засгийн амьдралд учруулж байгаа асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлох, эрчим хүчний зөв зохистой хэрэглээ болон бохирдлыг бууруулах арга, технологийн үр ашгийг дээшлүүлэх, шинэ технологи, дэвшилтэт зарим аргын талаар авч үзэн олон улсын туршлага, шинжлэх ухаан, орчин үеийн технологид тулгуурласан байгаль орчинд ээлтэй эрчим хүч, барилга, тээврийн салбарын төслүүд хэрэгжүүлэх боломжийг хайж, цаашид агаарын бохирдлыг бууруулах арга замыг оновчтой тогтооход Төрийн холбогдох байгууллагууд, ШУА, эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэд судлаачдын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлэв.

Улаанбаатарын дулааны шугам сүлжээний газар, МЭХА-тай хамтран “Дулаан хангамжийн хөгжил, шинэчлэл, шинэ технологи» олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.

### ***Шинжлэх ухааныг сурталчлах түгээн дэлгээүүлэх түгээн дэлгэрүүлэх талаар***

Эрчим хүчний салбарын болон ШУА-ийн үйл ажиллагаатай холбоотой телевизийн шууд ярилцлага болон мэдээллийн чанартай асуудлаар 8 удаа олон нийтийн телевизээр ярьсан болно.

Эрдэм клуб, академичдын цуврал лекцийг хариуцан зохион байгуулав.



## НИЙГМИЙН УХААНЫ САЛБАРЫН БАГА ЧУУЛГАН

### *Бага чуулганы бүтэц, бүрэлдэхүүн*

Нийгмийн ухааны салбарын бага чуулган 2014 оны 1 дүгээр сарын 14 өдрийн хуралдаанаар чуулганы гишүүний нөхөн сонгуулийг хийж, шинэ гишүүн 5, төрийн төлөөлөл 6 бүгд 11 гишүүнээр эгнээгээ тэлж, нийт 46 гишүүнтэй болсон. 2014 оны 1 дүгээр сарын 24 өдөр хийсэн хуралдаанаар салбарын бага чуулганы дарга, орлогч дарга нарыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж, Салбарын бага чуулганы даргаар академич Б.Жадамбааг, орлогч даргаар академич Т.Намжим нарыг тус тус улируулан сонголоо.

Нийгмийн ухааны салбарын бага чуулганы бүтцийг авч үзвэл Академийн гишүүн 17, сонгогдсон гишүүн 23, төрийн төлөөлөл 6, ШУА-ийн харьяа хүрээлэн, төвд ажилладаг 18, Их, дээд сургуульд ажилладаг 17, бусад байгууллагад ажилладаг 11 гишүүн тус тус байна.

ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын Бага чуулганы хүрээнд ШУА-ийн Археологийн хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэн, Философи, социологи, эрхийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Баян-Өлгий дахь Нийгэм-эдийн засгийн судалгааны төв, БСШУЯ-ны Боловсролын хүрээлэн, СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэн, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, МУИС, МУБИС, ШУТИС, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Ховд их сургууль зэрэг их дээд сургуулийн холбогдох салбар тэргүүтэн 16 эрдэм шинжилгээний байгууллага үйл ажиллагаа явуулж, тэдгээрээс ШУА-ийн харьяаны 8 байгууллагад 220 гаруй эрдэмтэн судлаач, академич 7, доктор (Sc.D) 14, доктор (Ph.D) 83, магистр 109 ажиллаж байна.

### *2014 онд хэлэлцэж шийдвэрлэсэн асуудал:*

Тайлангийн хугацаанд Бага чуулган нийт 5 удаа хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:

- Нийгмийн ухааны салбарын бага чуулганы 2010-2013 онд хийсэн ажлын тухай
- Салбарын бага чуулганы дарга, орлогч дарга нарыг сонгох тухай
- Тус салбарын Бага чуулганы гишүүдийг сонгох тухай
- Бага чуулганаас ШУА-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай
- Нийгмийн ухааны салбарт 2011-2013 онд хэрэгжүүлж дуусгасан суурь судалгааны сэдэвт ажлын тайлан хэлэлцэх тухай
- 2015-2017 онд хэрэгжүүлэх суурь судалгааны сэдэвт ажлыг хэлэлцэх тухай
- Салбараас 2014 оны Төрийн шагналд бүтээл дэвшүүлэх тухай
- Бага чуулганд үйл ажиллагааны төрөлжсөн багууд байгуулж, ажиллуулах тухай болно.



**Засгийн газар болон бусад байгууллагад хүргүүлсэн зөвлөмж, бодлогын баримт бичигт тусгуулсан асуудал:**

Тайлангийн хугацаанд салбарын бага чуулганаас 15 бодлогын зөвлөмж боловсруулан шийдвэр гаргагчдад хүргүүллээ. Үүнд:

1. “Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” зөвлөмжийг УИХ-ын Тамгын газар зэрэг байгууллагуудад хүргүүлсэн.
2. “Монгол улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам” зөвлөмжийг УИХ-ын Тамгын газар зэрэг байгууллагуудад хүргүүлсэн.
3. “Их, дээд сургуулиудын бүтэц, зохион байгуулалт” экспертийн судалгааны зөвлөмжийг БШУЯ-нд хүргүүлэв.
4. “БНХАУ, ОХУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, ач холбогдол”
5. “БНХАУ-ын хөгжилд шинжлэх ухааны салбарын гүйцэтгэж буй үүрэг, инновацийн бодлого, хөгжлийн төлөв” Бодлогын судалгаа хийж УИХ-ын гишүүдэд тараасан.
6. “Ази–Европыг холбох Эрээнцав-Бичигт-Зиньжоу эдийн засаг, тээврийн шинэ хонгил байгуулах тухай” бодлогын саналыг УИХ-д хүргүүлсэн,
7. “Монголын геополитикийн дэд бүтцийг байгуулах тухай /DEVELOPING MONGOLIA'S GEOPOLITICAL INFRASTRUCTURE/” бодлогын зөвлөмжийг монгол, англи хэлээр боловсруулж, шийдвэр гаргагчдад хүргүүлээд байна.
8. “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа” бодлогын зөвлөмж боловсруулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн;
9. “Үйлдвэржилтийг дэмжих арга замын тухай” бодлогын зөвлөмжийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн ;
10. “Монгол улсын төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой эрх зүйн орчны өнөөгийн байдал” бодлогын зөвлөмжийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн;
11. “Малын гаралтай түүхий эдээс уураг боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл боломж” бодлогын зөвлөмжийг боловсруулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн;
12. “Сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөв, иргэдийн оролцоог үр дүнтэй ашигласан туршлага, сургамж” зөвлөмжийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн;
13. “Хөгжлийн урт хугацааны бодлого” зөвлөмжийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн;
14. “Ногоон хөгжлийн бодлого” бодлогын зөвлөмжийг боловсруулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн байна.
15. “Монгол Улсын эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дэвшил гаргах боломж” бодлогын зөвлөмжийг Салбарын бага чуулганы эдийн засгийн төрөлжсөн багийн эдийн засагч эрдэмтэд боловсруулж, УИХ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газарт хүргүүлэв.

**Шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх талаар:**

Салбарын үйл ажиллагааны талаар мэдээллийг “Эрдэм” сонинд тогтмол нийтлэхийн



хамт түүхчид, хэл зохиол судлаачид тус сонины нижгээд дугаарын тус тус эрхлэн гаргаж, судалгааныхаа үр дүнг түгээн дэлгэрүүлсэн болно.

Салбарын хэмжээнд 23 эрдэм шинжилгээний цуврал, сэтгүүлийг тогтмол гаргаж байгаа бөгөөд түүгээр дамжуулан эрдэм шинжилгээний судалгааны үр дүн, шинжлэх ухааны ололтыг олон нийтэд сурталчилж байна.

Тайлангийн хугацаанд салбарын хэмжээнд үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал 37, үзэсгэлэн 6, төвийн сонины нийтлэл 81-г бичиж, 109 удаа радио, телевизийн ярилцлага, нэвтрүүлэгт оролцож судалгааны үр дүнгээ сурталчилах, нийгмийг соён гэгээрүүлэхэд ихээхэн анхаарч ажилласан байна.

Манай хэл шинжээчид Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний Тамгын газрын захиалгаар Монгол хэлний цахим тайлбар толь бүтээх ажлыг эхлүүлж Иргэний танхимд хэлэлцүүлэг зохион, эхний үр дүнг олон нийтэд хүргээд байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс санаачилсан “Нэг монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа энэхүү цахим, нээлттэй толь бичиг нь интернетийн орчинд хаанаас ч хандах боломжтой бөгөөд бас засварлах, нэмэх, дэлгэрүүлэх боломжтойгоороо онцлогтой юм. Монгол хэлний толь бичгийн салбарыг төрөл зүйлийн хувьд баяжуулсан уг толь нь орчин үеийн хөгжлийн чиг хандлагад нийцэн, хэрэглээний өргөн боломж олгож буйгаараа шинэлэг болно. Мөн БШУ-Сайдын тушаалаар батлагдсан монгол хэлний журамламал толь бичиг зохиох ажлыг хэл шинжээчид голлон гүйцэтгэж байна.

Нийгмийн ухааны салбараас нийслэлийн Ерөнхий боловсролын сургуультай хамтран ажиллахад анхаарч байна. Салбарын харьяа хүрээлэн төвүүд жил бүр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, нийслэлийн ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ сурталчилдаг уламжлал тогтов. Мөн манай судлаачид өөрийн судалгааны ажлын чиглэлээр ЕБС-д очиж лекц уншиж судалгааны үр дүнгээ хүүхэд залууст танилцуулж байна. 2014 оны байдлаар нийгэм судлаачид нийслэлийн 23, 24, 33, 69, 50 дугаар сургуулийн төгсөх ангийнханд “Хотын соёл”, “Эртний монголчуудын домгийн сэтгэлгээ”, “Нийслэлийн иргэн”, “Харилцааны ёс зүй” зэрэг сэдвээр 27 удаагийн лекц яриа зохион байгуулсан байна.

“Монголын боловсролын тулгамдсан асуудлууд” сэдвээр Нийгмийн ухааны салбарын шинээр сонгогдсон академич Н.Бэгз лекц уншив.





## МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ АКАДЕМИ

МАУА-ийн гишүүний сонгууль явуулж 9 гишүүн шинээр сонгогдож, 44 гишүүнтэй, 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.


МАУА-ийн чуулганы хуралдааныг 5 удаа зохион байгуулж, 2013 оны үйл ажиллагааны тайлан, ШУА-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, МАУА-ийн гишүүний сонгууль явуулах, 2013 онд хэрэгжүүлж дууссан суурь судалгааны тайлан, 2015 оноос хэрэгжүүлэх суурь судалгааны сэдвүүд, Төрийн шагналд бүтээл дэвшүүлэх тухай, анагаах ухааны онцгой анхаарах асуудлаарх ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Судалгааны цар хүрээ өргөжиж, чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой амжилтад хүрлээ. 2014 онд анагаах ухааны салбарт 540/330 эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж, 3,8 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт (дотоод, гадаадын)-ээр шинжлэх ухаан технологийн 63 судалгааны ажил гүйцэтгэж, 128 ном, товхимол, 613 өгүүлэл (93 гадаад, 520 дотоод), 1118 илтгэл (319 гадаад, 799 дотоод) хэлэлцүүлж, шинэ бүтээлийн патент 26, ашигтай загварын гэрчилгээ 4, Зохиогчийн эрхийн гэрчилгээ 8-ийг авч, оношлогоо, эмчилгээний стандарт 38, технологийн заавар 44, Фармакопейн өгүүлэл-14-ийг батлуулж, Шинэ эм-12-ийг бүтээсэн байна.

Томуугийн вирүсийн 387 омгийн нейраминидазын саатуулуур эмэнд тэсвэржилтийн фенотип шинжилгээ хийж, Монголд ялгасан 31 омгийн M2, NA генийн нүклеотидын дараалал, бэтэг өвчний үүсгэгчийн 23 генийн дарааллыг тогтоож, олон улсын зөвшилцсөн сан GenBank-д оруулан хадгалуулсан байна.

Ази, номхон далайн орнуудын анагаах ухааны сэтгүүлүүдийн холбоо (APAME)-ийн чуулган зохион байгуулж, APAME, WPRIM (Номхон далайн баруун бүсийн анагаах ухааны сэтгүүлүүдийг индексжүүлэх байгууллага)-ын хамтарсан хурал хийж, эдгээр арга хэмжээнд 15 орны 52, монгол улсын 110 гаруй төлөөлөгч оролцлоо. Энэхүү хурлыг зохион байгуулснаар Монголын анагаах ухааны сэтгүүлүүдийн холбоо нь Ази, Номхон далайн сэтгүүлүүдийн холбооны гишүүний хувьд хамтын ажиллагааны үүргээ гүйцэтгэж, анагаах ухаан, эрүүл мэндийн салбарт шинэ мэдлэг, мэдээлэл хуваалцах, түгээхэд тодорхой хувь нэмэр орууллаа.

Анагаах ухааны бүтээл бичих арга зүйн олон улсын сургалт зохион байгуулж, анагаах ухааны салбраас 50 залуу эмч, судлаачийг хамруулж, сертификат олгож, ЭМЯ, ХӨСҮТ, Бангкок дахь АНУ-ын Цэргийн анагаах ухааны хүрээлэн, Ази, Номхондалайн анагаах ухааны ёсзүйн хорооны чуулган зэрэг байгууллагууд хамтран Хүнийг оролцуулсан судалгааны ёсзүйн сургалтыг зохион байгуулж, анагаах ухааны чиглэлээр судалгаа явуулдаг сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын 30 төлөөлөгч хамрагдав.



МАУА-аас эрхлэн гаргаж буй “Монголын анагаах ухаан” сэтгүүлийн 2014 оны 4 дугаарыг бэлтгэж, хэвлүүлж, нийтийн хүртээл болгож, анагаах ухааны сэтгүүлийн цахим мэдээний сан “МонголМед”-д байршуулав. “МонголМед” мэдээний санг баяжуулж, Монголын анагаах ухаан, “Mongolian Journal of Health Sciences”, “Дорно дахины анагаах ухаан”, “Монголын уламжлалт анагаах” ухаан, “Онош”, “Халдварт өвчин судлалын монголын сэтгүүл”, “Эрүүл мэндийн шинжлэх ухаан” сэтгүүлүүдийн мэдээллийг нэмж оруулснаар тус мэдээний сангаас монголын анагаах ухааны салбарын эрдэм шинжилгээний 10 сэтгүүлийн 4000 гаруй өгүүллийг унших боломжтой боллоо.

Анагаах ухааны ололтыг түгээх чиглэлээр МАУА-ийн гишүүд гадаад, дотоодын эрдэм шинжилгээний 56 хуралд илтгэл хэлэлцүүлж, телевизийн 15 нэвтрүүлэгт оролцож, 26 удаа лекц зохион байгуулжээ.



## МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн гишүүдээр өргөтгөсөн Эрдмийн зөвлөлийн хуралдааныг 1 удаа тус тус зохион байгуулж, салбарын шинжлэх ухаан, боловсролын бодлого боловсруулах, баталгаажуулах, цаашдын хөгжлийн хөтөлбөр хэлэлцэж батлуулах, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх судалгааны төсөл, онолын суурь судалгааны ажлын сэдэв дэвшүүлэх зэрэг асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэрүүдийг тухай бүр гаргуулж ажиллав.

### ***Гадаад хамтын ажиллагаа:***

ОХУ-ын ХАА-н шинжлэх ухааны академийн Сибирийн салбартай хамтран ажиллаж, “Хөдөө аж ахуйг үйлдвэрлэлд салбарын шинжлэх ухааны үүрэг” сэдэвт XVII удаагийн эрдэм шинжилгээны олон улсын бага хурлыг ОХУ-ын Новосибирск хотны 2014 оны 11 дүгээр сард зохион байгуулав.

Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Дархан-Уул аймагт НҮБ-ын ХХААБ-аас эрэгжүүлж буй “Ургамал хамгааллын салбарын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Улаанбуудайн ургамал хамгааллын цогцолбор арга”, “Хүлэмжийн ургамал хамгааллын цогцолбор арга”, “Үйлдвэрлэгчдэд ургамал хамгааллын цогцолбор аргыг танилцуулах” зэрэг сэдэвт сургалтуудыг амжилттай зохион байгуулав

### ***Шинжлэх ухааны хөгжлийн бодлого тодорхойлох, хамтын ажиллагааны менежмент:***

Салбарын болон Монгол Улсын хөгжлийн чиглэл, хандлага тодорхойлох бодлогын баримт бичиг боловсруулах жилд манай судлаачид, академийн ажлын алба идэвхи санаачлагатай ажиллаж БШУЯ-ны захиалгаар ШУТ-ийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг шинэчлэн боловсруулах, ҮХААЯ-ны захиалгаар Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичиг зэргийг боловсруулан хүлээлгэн өгөв.

“Оны шилдэг технологи шалгаруулах журам”-ын дагуу Хөдөө аж ахуйн салбарын 2014 оны шилдэг технологи шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулав.

Докторын дараах судалгааны ажлын грант төсөлд 5 судлаач судалгааны ажлын төсөл ирүүлнээс МЭХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан М.Золзаяагийн “Мөнгөний ионоор идэвхжүүлсэн цеолитын бэлдмэл” сэдэвт грант шалгарч, 2 сая төгрөгний санхүүжилт авав. Түүнчлэн “Хүрэлтогоот-2014” эрдэм шинжилгээний бага хурлын салбар хуралдаануудад амжилттай оролцож, I, II байр эзэлсэн УХЭШХ, МААБС, АЭС-ийн судлаач, багш нарт тус бүр 1 сая төгрөгийн судалгааны ажлын грант олгов.



## ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ

### ОЛОН УЛСЫН ХУРАЛ, СУРГАЛТ, СЕМИНАР, ҮЗЭСГЭЛЭН

- 1 2014.02.12 Монгол улсын Шинжлэх ухааны Академийн гишүүнийг сонгох журмын дагуу академийн гишүүнд нэр дэвшсэн эрдэмтдийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж, тэдний бүтээлийг олон нийтэд дэлгэн үзүүлэв.
- 2 2014.02.27 Отгонтэнгэр Их Сургууль, Идэр дээд сургуультай хамтран “Монгол улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 3 2014.02.28 “Өндөр гэгээн” монгол соёлын төв, Гандантэгчилэн хийд Эрдэм соёлын хүрээлэнтэй хамтран анхдугаар богд, Өндөр гэгээн Занабазарын “Сарьдагийн хийд” байгуулагдсаны 360 жилийн ойд зориулсан “Анхдугаар богд, Өндөр гэгээн Занабазар” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 4 2014.03.19 Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой, Монгол-Японы палеонтологийн хамтарсан экспидецийн 20 жилийн ойн хүрээнд Японы Токио, Осака зэрэг томоохон хотуудад зохион байгуулагдсан Монгол орон, Монголын ШУ-ны ололт амжилтыг сурталчлах зорилготой “Монголын говь: Үлэг гүрвэлийн гайхал төрүүлэм өлгий нутаг” үзэсгэлэн.
- 5 2014.04.04 БОНХЯ-тай хамтран “Ургамлын биотехнологи-2014” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 6 2014.04.08 ХБНГУ-тай дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ХБНГУ-ын ЭСЯ, ССАЖЯ, Монгол Үндэсний Музей, Бонны их сургуультай хамтарсан “Талын дайчдын өв соёл” үзэсгэлэнг зохион байгуулав. Үзэсгэлэнг 55 мянга гаруй хүн үзэж сонирхжээ.
- 7 2014.04.18 “Хятаны өв соёл” эрдэм шинжилгээний хурлыг Монголын Үндэсний Музей, МУИС, ШУТИС, СУИС зэрэг түүх-археологийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран зохион байгуулав.



- 8 2014.04.22 Улаанбаатар хотын Төв номын сантай хамтран “Улаанбаатар хотын хөрсний бохирдол” сэдэвт уулзалт лекц зохион байгуулав. Тус лекц нь “Дэлхийн байгаль хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд олон нийтэд нээлттэй явагдсан юм.
- 9 2014.04.24-25 “Байгалийн нөөцийн хамтын менежментийг хөгжүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн ан агнуурын менежмент, зэрлэг амьтдын мониторинг судалгаа” сэдэвт сургалтыг Өвөрхангай аймгийн Байгаль орчны газар, Зооноз өвчин судлалын газартай хамтран Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баян тээг багт зохион байгуулав.
- 10 2014. 05.01 Ботаникийн хүрээлэнг үүсгэн байгуулагч Д.Банзрагчийн мэндэлсний 80 жилийн ойд зориулсан оны шилдэг илтгэл шалгаруурлах эрдэм шинжилгээний семинар зохион байгуулав.
- 11 2014.05.02 Сангийн яамтай хамтран ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийн захирал, санхүүгийн албан хаагчдад зориулсан “Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, Төрийн сангийн үйл ажиллагаа, Худалдан авах ажиллагааны АЗ сертификат, Гадаад төслийн санхүүжилт, үр дүн” сэдвээр сургалт зохион байгуулав.
- 12 2014.05.07 ШУА-ийн Эрдэм клубээс “Монгол дахь хотжилт: үйл явц ба төлөв байдал” сэдэвт лекц-хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- 13 2014.05.09 Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Р.Отгонбаатарын Хубилай хааны үеийн дөрвөлжин үсгийн нэгэн шинэ дурсгалыг Монголын хүүхдийн номын ордонд тайлбарт үзэсгэлэн хэлбэрээр толилууллав.
- 14 2014.05.15-17 Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимтай хамтран байгаль орчинд хор хөнөөлгүй шинэ техник, технологи, оновчтой шийдэл, шинэ санаачилгыг сурталчлах, мэдээллийн сан бүрдүүлэх, тэднийг бодлогоор дэмжих, мөн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор “Байгаль орчинд ээлтэй техник, технологи-2014” үзэсгэлэнг зохион байгуулав.
- 15 2014.05.15 “Ногоон алт” төсөлтэй хамтран Академич Ц.Даваажамцын нэрэмжит “Монгол орны ургамалжил-2014” эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.





- 16 2014.05.20-21 БНХАУ-ын ШУА-ийн Ботаникийн хүрээлэнтэй хамтран Бээжин хотноо “Regional Workshop on Vegetation Adaptation and Function in Northeast Asia Grassland ” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 17 2014.05.22 ССАЖЯ-ны харъяа Аялал жуулчлалын үндэсний төвтэй хамтран, аялал жуулчлалын салбарт дэвшилтэт EM технологийг нэвтрүүлэх зорилгоор “Жуулчны баазуудын ногоон байгууламж, экологийг сайжруулах, жуулчдын амрах, аялах тав тухтай, эрүүл орчинг бүрдүүлэх асуудал” сэдэвт сургалт-хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- 18 2014.05.22 Дорноговь аймгийн Засаг Даргын Тамгын газартай хамтран “Хамтдаа бүтээх таны боломж” шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн форумыг Дорноговь аймгийн Сайншанд хотноо зохион байгуулав.
- 19 2014.05.23 МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургууль, МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургууль, ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургуультай хамтран “Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.
- 20 2014.05.28 Монгол, Вьетнам улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд “Монгол, Вьетнамын найрсаг харилцаа нэгэн жаранд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.
- 21 2014.05.30 Монголын оюунлаг эрдэмтэн эмэгтэйчүүдийн холбоо, Эмэгтэй эрдэмтдийн холбоо, их дээд сургуультай хамтран “Инновацийн хөгжилд эрдэмтэн эмэгтэйчүүд” уриан дор “Монголын эрдэмтэн эмэгтэйчүүдийн II чуулган”-ыг Төрийн ордны Их танхимд зохион байгуулав.
- 22 2014.06.05 Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтран “Үндэсний инновацийн тогтолцоо, Инновацийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт сургалт зохион байгуулав.
- 23 2014.06.6-7 НАТО-той хамтарсан “Энх тайвны төлөөх шинжлэх ухаан” төслийн хүрээнд Монгол Улсын Батлан хамгаалах яам, БОНХЯ-тай хамтран “Цэргийн зориулалтаар ашиглах газрын экологийн нөхцөл байдлын судалгаа” сэдэвт сургалт семинарыг зохион байгуулав.



- 24 2014.06.11 Монгол Үндэсний Ардчилсан намтай хамтран “Үндэсний үзэл-Үндэстэн улсын хөгжил” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- 25 2014.06.12 МУИС-ийн Хүмүүнлэгийн сургуулийн Түүхийн тэнхим болон Монгол уламжлалын академитай хамтран “Монголын түүх судлал: түүхийн философи, шинэ хандлага, тулгамдсан асуудлууд” сэдэвт симпозиумыг зохион байгууллаа.
- 26 2014.06.13 ОХУ-ын Сохондинскийн ДЦГ, АНУ-ын Олон улсын тогорууны сан, Хэнтий, Онон Балж, Хар ямаат зэрэг тусгай хамгаалалттай газрын захиргаа, Зэрлэг амьтан судлах хамгаалах төвтэй хамтран Хэнтий аймгийн Биндэр суманд “Тогорууны фестиваль”-ийг зохион байгуулав.
- 27 2014.06.25-28 Монгол-Орос-Хятадын хамтарсан Даурын Олон улсын ДЦГ-ын 20 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Дорнодын Дашбалбар суманд зохион байгуулав.
- 28 2014.06.27 ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын Бага чуулган ОХУ-ын Буриадын их сургууль болон Тасралтгүй боловсролын хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй “Орчин үеийн олон соёлын уулзвар дахь боловсрол” төслийн хүрээнд “Монголчуудын шашин шүтлэг” сэдэвт дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулав.
- 29 2014.07.15-19 Увс нуурын ай савын УТХГХЗ-ны 20 жилийн ойд зориулсан “Төв Азийн экосистем: Судалгаа, хамгаалал, зохистой ашиглалт” сэдэвт “Увс нуур” Олон улсын ээлжит 12-р симпозиумыг хамтран зохион байгуулав.
- 30 2014. 07. 21 Японы Үндэсний Технологи ба Үнэлгээний хүрээлэнтэй хамтран “Бичил биетний молекул филогенетик шинжилгээний үндэс” сэдэвт сургалтыг зохион байгуулж, орчин үеийн молекул ангилал зүйн аргуудыг танилцуулав.
- 31 2014.08.01 Тайваний Синика академитай хамтарсан “Тайвань, Монгол дахь цахим суралцахуй ба цахим архив”, “Ургамлын генийн инженерчлэл хөдөө аж ахуй, ногоон энергид” сэдэвт олон улсын семинар зэргийг зохион байгуулав.



- 32 2014.08.15-16 БНХАУ-ын ШУА-ийн Газарзүйн хүрээлэн, ӨМӨЗО-ны Багшийн Их Сургууль, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Байгаль нуурын хүрээлэн хамтран “Монголын тэгш өндөрлөг, түүний зэргэлдээх нутгийн байгаль орчин, тогтвортой хөгжил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага БНХАУ-ын Хөх Хотод зохион байгуулав.
- 33 2014.08.18-20 МУИС-ийн ФЭС болон ШУТИС-ийн Материал судлалын сургуультай хамтран “Материал судлал” (Material Science) сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний ээлжит III бага хурлыг зохион байгуулав.
- 34 2014.08.22-23 Токиогийн гадаад судлалын их сургууль, МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн болон холбогдох байгууллагуудтай хамтран “Монголын газрын зураг, газрын нэрийн түүх-соёлын судалгаа” сэдэвт олон улсын бага хурал зохион байгууллаа.
- 35 2014.09.02 ХБНГУ-тай дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын ШУА, 1241 онд байгуулагдсан Ваальштадтын ах дүүсийн холбоотой хамтран “Монгол-Европын түүхэн учрал” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 36 2014.09.03 Их Британий Кембрижийн их сургуулийн Монгол, Өвөр Ази судлалын төвтэй хамтран Британий академийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Entangled Lines: Railways, Resource Booms, Transnational Politics in Mongolia” эрдэм шинжилгээний төслийн дунд шатны үр дүнд Британий Кембрижийн Их сургуулийн Монгол, Өвөр Азийн судалгааны төв, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран “Халх голын дайн ба төмөр зам” сэдэвт олон улсын симпозиумыг зохион байгуулав.
- 37 2014.09.05 Түүхчид Япон, ОХУ, БНХАУ –ын эрдэмтэдтэй хамтран зохион байгуулсан “Евроазийн нүүдлийн аж ахуй: түүх, соёл, хүрээлэх орчин” олон улсын эрдэм шинжилгээний хурал нь Евроазийн нүүдлийн аж ахуй, ард түмний түүх, соёл, хүрээлэх орчин, нүүдлийн аж ахуй эрхлэлтийн уламжлал, шинэчлэл, хөгжлийн чиг хандлагыг тодруулах, цаашдын зорилтыг тодорхойлоход чиглэсэн анхны хурал болов.
- 38 2014.09.14-16 БНСУ-ын Зүүн хойт Азийн түүхийн сантай хамтарч “Зүүн хойт Ази ба Монгол, Солонгос” сэдвээр бага хурал зохион байгуулав.



- 39 2014.09.15 Финлянд улсын Ой судлалын хүрээлэн, МУИС-ийн Ойн тэнхимтэй хамтран “Монгол -Финляндын ойн судалгаа” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулав.
- 40 2014.09.26 УИХ-ын Тамгын газартай хамтран “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллганд судалгааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.
- 41 2014.09.30 Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жил, Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулсны 20 жилийн ойг тус тус тохиолдуулан Монгол, Хятадын мөнгө санхүүгийн харилцаа эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.
- 42 2014.10.09 Улаанбаатарын дулааны шугам сүлжээний газар, МЭХА-тай хамтран “Дулаан хангамжийн хөгжил, шинэчлэл, шинэ технологи” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 43 2014.10.10 Монгол улсад палеонтологийн салбар үүсч хөгжсөний 50 жилийн ойд зориулсан “Палеонтологи ба стратиграфи” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.
- 44 2014.10.14-16 ЮНЕСКО-гийн Бээжингийн товчоо, Монголын Үндэсний комисс, Боловсрол, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн, Шинжлэх ухаан технологийн их сургууль болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран “Шинжлэх ухаан, технологи, инновацийн шалгуур үзүүлэлт” үндэсний сургалт семинар зохион байгуулав.
- 45 2014.10.15 Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, МУИС, ШУТИС зэрэг байгууллагуудтай хамтран Монгол улсад үндэсний Геологийн алба байгуулагдсаны 75 жилийн ойд зориулан “Монгол орны геологийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.
- 46 2014.10.17 Монголын Залуу Эрдэмтдийн Холбоо, Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Шинжлэх Ухаан Технологийн Сан болон их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран уламжлалт “Хүрэлтогоот-Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал”-ыг зохион байгуулав.



- 47 2014.10.17 Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 375 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Архивын газартай хамтран “Нүүдлээс суурьшилд” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 48 2014.10.17 Олон нийтийг соён гэгээрүүлэх, шинжлэх ухааныг олон нийтэд сурталчлан таниулах эрхэм зорилгын хүрээнд явагддаг “Академичдын цуврал лекц” хөтөлбөрийн хүрээнд академич Д.Хайсамбуугийн “Монгол уран барилгын хөгжил, онол, арга зүй” сэдэвт лекцийг зохион байгуулав.
- 49 2014.10.17 Ботаникийн хүрээлэнгийн үүсэн байгуулагдсаны 40 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал.
- 50 2014.10.24 “Улсын нэр томьёоны комисс” байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан Монгол улсад орчин цагийн шинжлэх ухааны олон салбарын нэр томьёог оноон тогтоож ирсэн уламжлал болон орчин цагийн нэр томьёо судлалд тулгамдаж буй асуудлаар “Монгол нэр томьёо судлал-90” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг “Монгол судлалыг дэмжих сан”-тай хамтран зохион байгуулав.
- 51 2014.10.30-31 Монгол улсад Үндэсний инновацийн тогтолцоог 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд БСШУ-ны Яамтай хамтран “Боловсон хүчнээ чадваржуулъя” сэдэвт арга зүйн семинар зохион байгуулав.
- 52 2014.11.15 Төрийн болон төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиуд, Монголын Физикийн Нийгэмлэг, аж ахуйн нэгж, хувийн сектор болон гадаадад ажиллаж сурч буй физикчидтэй хамтран “Физикчдийн үндэсний II форум”-ыг зохион байгуулав.
- 53 2014.11.19 Монгол Үндэсний Ардчилсан Намтай хамтран УИХ-ын гишүүдийн оролцоотойгоор “Монгол улсын Үндсэн хуулийн шинэчлэлийн асуудал” сэдвээр эрдэм шинжилгээний хурал-хэлэлцүүлэг зохион байгуулав.
- 54 2014.11.20 Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисстой хамтран “Ертөнцийн шинжлэх ухааны дүр зургийн өөрчлөлт ба философи” сэдэвт симпозиум зохион байгуулав.





- 55 2014.11.24 Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Яам, Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Монголын Үндэсний Номын Сан, Монгол Судлалыг Дэмжих Сан, Монголын Архивын Ерөнхий Газар, Монгол Ардын Нам, Дорнод Аймгийн Нутгийн Зөвлөл, Дорнод Дээд Сургууль зэрэг байгууллагатай хамтран Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч Онходын Жамъян гүнгийн мэндэлсний 150 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 56 2014.11.26 Өмнөговь аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран “Өмнөговийн түүх соёлын өв: Өнөө ба ирээдүй” онол практикийн бага хурал-хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
- 57 2014.11.26 Олон нийтийг соён гэгээрүүлэх, шинжлэх ухааныг олон нийтэд сурталчлантаниулах эрхэм зорилгын хүрээнд явагддаг “Академичдын цуврал лекц” хөтөлбөрийн хүрээнд академич Н.Бэгзийн “Монголын боловсрол судлалын хөгжлийн асуудлууд” сэдэвт лекцийг зохион байгуулав.
- 58 2014.11.26-27 Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан Боловсрол, шинжлэх ухааны яам, Шинжлэх ухааны технологийн сантай хамтран “Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны олон талт оролцоо” сэдэвт чуулга уулзалтыг зохион байгуулав.
- 59 2014.11.27 НАТО-той хамтарсан “Энх тайвны төлөөх шинжлэх ухаан” төслийн хүрээнд хэрэгжсэн “Цэргийн зориулалтаар ашиглах газрын экологийн нөхцөл байдлын судалгаа” төслийн тайлангийн хурлыг зохион байгуулав.
- 60 2014.11.27 ШУА-ийн Техник технологийн салбарын бага чуулганаас санаачлан Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, БОНХЯ-тай хамтарсан “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга зам, боломжууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал-хэлэлцүүлгийг зохион байгуулж, зөвлөмж боловсруулав.
- 61 2014.11.28-29 Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан Боловсрол, шинжлэх ухааны яам, Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран “Шинжлэх ухаан, үйлдвэрлэл-2014” үзэсгэлэнг Монголын уран зургийн Галларейн үзэсгэлэнгийн танхимд зохион байгууллаа.



- 62 2014.12.11 АНУ-ын Азийн сан, Америкийн Монгол Судлалын Төвийн Монголд зориулсан ном хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Монголын Номын Сангуудын Консорциум Төрийн бус байгууллага (ТББ)-тай хамтран “Нээлттэй мэдээлэл, мэдлэгийн хүртээмж ба эрдэм шинжилгээний тогтвортой харилцаа” сэдэвт семинарыг зохион байгуулав.
- 63 2014.12.12 ШУА-ийн Эрдэм клубээс “Улс хөгжихийн үндэс машины үйлдвэрлэл, түүний эхлэл нь засварын жижиг дунд үйлдвэрүүд мөн” сэдэвт ярилцлага-хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- 64 2014.12.17 Олон нийтийг соён гэгээрүүлэх, шинжлэх ухааныг олон нийтэд сурталчлан таниулах эрхэм зорилгын хүрээнд явагддаг “Академичдын цуврал лекц” хөтөлбөрийн хүрээнд Монголын Залуу Эрдэмтдийн холбоо, Монгол Ардын Нам, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз болон Монголын залуу эрдэмтдийг дэмжих сан зэрэг байгууллагуудтай хамтран Чингисийн одонт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт, академич Хавтгайн Намсрайн залуу судлаачдад зориулсан “Орчин үеийн физикийн шинжлэх ухаан ба ирээдүйн авьяасыг нээх зарим арга зам, жишээнүүд” сэдэв лекцийг зохион байгуулав.
- 65 2014.12.18 ШУА-ийн ФМХ-ийн салбарын бага чуулганаас санаачлан Монголын химич химийн инженерүүдийн холбоо, Уул уурхайн яамтай хамтран “Монголд нүүрс-химийн үйлдвэрлэл хөгжүүлэх асуудал” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.
- 66 2014.12.24 Монголын төр нийгэм, боловсрол, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн академич Т.Пунцаг агсаны 90 жилийн ой, Микробиологийн салбарын 40 жилийн ойд зориулан “Монгол орны бичил биетэн-2014” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- 67 2014.12.26 Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн академич Чимидийн Сэрээтэрийн мэндэлсний 90 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.



## ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

### ГАДААД ХАРИЛЦАА

ШУА нь гадаад харилцааг хөгжүүлэх, харилцаа бүхий орнуудын шинжлэх ухааны академиудтай байгуулсан гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны протокол, төлөвлөгөөны заалтыг хэрэгжүүлэх, зарим орны шинжлэх ухааны байгууллагуудтай шинээр харилцаа холбоо тогтоох, эрдэм шинжилгээний хамтарсан төсөл хэрэгжүүлэх, экспедиц, олон улсын хурал, семинар зохион байгуулах, эрдэмтэн солилцоог өргөтгөх, харилцаа, мэдээллийг хөгжүүлэх зэрэгт анхаарч ажиллаж байна.

Бид 2014 онд гадаадын 9 орны нийт 13 эрдэм шинжилгээний байгууллагуудтай шинээр гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулсан байна.

2014 онд байгуулсан Гэрээ хэлэлцээрүүд

1. Монгол Улсын ШУА, Хельмхольцийн нийгэмлэгийн Фрайбергийн эрдсийн нөөцийн хүрээлэн хооронд 2014 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав;
2. МШУА, Халлегийн Мартин Лютерийн их сургуультай хамтран ажиллах Хэлэлцээрийг 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр байгуулав;
3. Казакстаны Түрэг академийн ерөнхийлөгч Дархан Кыдырали ШУА-д айлчилж Дорно дахины судлал, Алтай судлал, Түрэг судлал, Монгол судлалын салбарт хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурав;
4. Италийн Үндэсний судалгааны зөвлөл (CNR)-ийн ерөнхийлөгч ноён Луизи Николаис 2014 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Улаанбаатар хотноо Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав;
5. Тайваний “Синика” академийн ерөнхийлөгч Чи-Хуэй Вонг тэргүүтэй төлөөлөгчид 7 дугаар сарын 28-наас 8 дугаар сарын 1-ний хооронд ШУА-д айлчлав. Айлчлалын хүрээнд хамтын ажиллагааны талаар санал солилцож, Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав;
6. Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн урилгаар Өвөр Монголын Ардын Засгийн газрын Орлогч дарга Бай Шанчунь, Боловсролын яамны сайд Хоу Юань тэргүүтэй төлөөлөгчдийн айлчлалыг хүлээн авч Монгол Улсын ШУА, Өвөр Монголын Их



Сургуультай хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулав;

7. Дээрх айлчлалын хүрээнд Өвөр Монголын Багшийн Их Сургуультай хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулав;
8. Монгол-Германы шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Шинжлэх ухааны Академи, ХБНГУ-ын Бонны Их Сургууль хоорондын Монгол-Германы Хархорин Экспедицийн хамтын ажиллагааг 2019 хүртэл үргэлжлүүлэх хамтын ажиллагааны Гэрээг байгуулав;
9. Монголын ШУА, Малайзын Шинжлэх ухааны Их сургууль (USM) хоорондын шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах Гэрээ 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр байгуулав;
10. Монгол Улсын ШУА, ОХУ-ын Буриадын Улсын Их Сургуулийн хооронд хамтран ажиллах тухай Хэлэлцээрт 2014 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав;
11. Энэтхэгийн Үндэсний ШУА, Монголын ШУА хоорондын Харилцан ойлголцлын Санамж бичигт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Нью Дели хотноо гарын үсэг зурав;
12. Унгарын ШУА-д хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ШУА-ийн Ерөнхийлөгч Б. Энхтүвшин Унгарын ШУА-д 2014 оны 11 дүгээр сард айлчлах үеэр 1995 онд байгуулсан хамтын ажиллаганы Хэлэлцээр, түүний протоколыг шинэчлэн байгуулав;
13. Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга, Оросын түүхийн холбооны тэргүүн Сергей Нарышкины Монгол улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, Оросын Түүхийн нийгэмлэгийн тэргүүн С.Е.Нарышкин нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг санамж бичигт хоёр тал Орос-Монголын түүхийн нийтлэг асуудлаар хамтран судалгаа хийх, түүхийн шинжлэх ухааныг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчилахад хамтран ажиллахаар тусгажээ.

ШУА нь гадаадын 30 орчим орны 100 гаруй эрдэм шинжилгээний байгууллагуудтай нийт 167 орчим гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хөтөлбөр бусад төрлийн баримт бичгийн хүрээнд хамтын ажиллагаа явуулж байна. Эдгээр баримт бичгүүдийн хүрээнд ШУА нь салбарын хүрээлэн төвүүдийн залуу судлаач нарыг олон улсын хуралд зөвлөгөөнд оролцуулах, гадаад оронд магистрантур, докторантурт суралцуулах ажлыг бодлого үйл ажиллагаагаар байнга дэмжин ажилладаг. Энэ оны байдлаар өндөр түвшний судалгааны төв, их сургуулийн магистрантурт 14, доктор болон докторын дараах сургалтанд манай 98 судлаач суралцаж байна.



Түүнчлэн 2014 онд ШУА-ийн харьяа хүрээлэн төвөөс нийт 134 эрдэм шинжилгээний ажилтан АНУ, ХБНГУ, Япон, БНХАУ, ОХУ БНСУ зэрэг улсад урт болон богино хугацаагаар мэргэжил дээшлүүлсэн байна.

ШУА-ийн 117 эрдэмтэн олон улс, бүс нутгийн судалгааны төсөл хөтөлбөрт оролцож, манай эрдэмтэд судалгааныхаа чиглэлээр байр суурь нь бэхжин тэднийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл нь Монгол улсын ШУА-ийг Азийн ШУА-иуд нийгэмлэгүүдийн холбооны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр сонгосон явдал мөн.

ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Б. Энхтүвшин 2014 оны 10 дугаар сард Энэтхэгийн Дели хотноо болсон Азийн Шинжлэх ухааны академиуд, Нийгэмлэгүүдийн холбооны дээд хэмжээний уулзалтаар уг Холбооны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр сонгогдов.

Монгол Улсын ШУА-ийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсад нэр хүнд бүхий байгууллагуудтай хамтран хурал зөвлөгөөн зохион байгуулах, илтгэл тайлан илгээж мэдээлэл харилцан солилцох чиглэлээр идэвхитэй ажиллав. Үүнд:

- Шинжлэх ухааны олон улсын зөвлөл(ICSU)-ийн 31 дүгээр Ерөнхий ассамблей;
- Азийн Шинжлэх ухааны зөвлөлийн 14 дэх ээлжит чуулган;
- Азийн Шинжлэх ухаан, нийгэмлэгүүдийн холбооны Удирдах, Гүйцэтгэх зөвлөлийн ээлжит хуралдаан;
- Азийн шинжлэх ухааны редакторуудын чуулган;
- Туркийн ШУА, Азийн Шинжлэх ухааны зөвлөл, хамтарсан “Эмэгтэйчүүдийн шинжлэх ухаан, технологид оролцоо” сэдэвт Ази тивийн шинжлэх ухааны семинар;
- Солонгосын Шинжлэх ухаан, технологийн академи (KAST) Азийн Шинжлэх ухааны зөвлөл, Малайзын Шинжлэх ухааны академи (ASM) хамтарсан “шинжлэх ухааны мэдлэг, олон нийтийн ойлголт” сэдэвт Ази тивийн семинар;
- Москва хотод төвтэй Шинжлэх ухаан технологийн мэдээллийн олон улсын төвийн гишүүн орнуудын бүрэн эрхт төлөөлөгч орнуудын 65 дугаар хуралдаанд “Шинжлэх ухаан ба инноваци үндэсний туршлага, олон улсын хамтын ажиллагаа” сэдэвт хуралдаануудад амжилттай оролцон илтгэл тавьж хэлэлцүүлээ.

### **Эрдэмтэн солилцооны хүрээнд:**

- DFG-ийн дэмжлэгээр Физик, технологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч Ц.Баатар ХБНГУ-ын Хелмхольцын хүрээлэнд 3 сарын хугацаагаар эрдэмтэн солилцооны хөтөлбөрт хамруулав.
- UNINET-ийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд ШУА-ийн Анагаах ухааны академи хариуцсан референт Д.Энх-Амгалан Австрийн Венийн анагаах ухааны их сургуульд 3 сарын хугацаагаар эрдэмтэн солилцоогоор ажиллав.
- DAAD-ын хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Хими, химийн технологийн хүрээлэнгийн ЭШТА Ж.Тунсаг Дрездений Их сургуулийн Химийн технологийн газарт





ажиллав.

- DAAD-ын хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Проф. Б.Алтантуяа Аахэны Их сургуульд эрдэм солилцооны хөтөлбөрт хамрагдав.
- ХБНГУ-ын Бонны Их сургуулийн багш, доктор Эрнст Пол ШУА-ийн Археологийн хүрээлэнд эрдэмтэн солилцоогоор ажиллав.
- Дортмундийн их сургуулийн багш, профессор Ларс Хармсен, Оливер Лангбейн, Александр Бранчик нар Монгол Улсын Соёл урлагийн их сургуульд эрдэмтэн солилцоогоор ажиллав.
- Бонны их сургуулийн багш, профессор Жан Бемманн, Урсула Бросседер нар Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнд эрдэмтэн солилцоогоор ажиллав.
- БНУУ-ын Шинжлэх ухааны академийн Этнологийн хүрээлэнгийн ЭША, доктор Жолт Жилаги Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэнгүүдэд эрдэмтэн солилцоогоор ажиллав.
- ХБНГУ-ын Дрездений Техникийн их сургуулийн Органик химийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор М.Грунер ШУА Хими, химийн технологийн хүрээлэнд эрдэмтэн солилцоогоор ажиллав.



## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ

### ХАРЬЯА ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗАРИМ ГОЛЛОХ ҮР ДҮНГЭЭС:

Монгол улсын ШУА 2014 оныг “Чанарыг дээшлүүлэх, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах” жил болгон зарлаж, судалгаа шинжилгээний ажлын нийгмийн үр өгөөжийг сайжруулахад ихээхэн анхаарч ажиллав. Академик байгууллагын зүгээс оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах олон хэлбэрийн нэг бол судалгааны үр дүнг шийдвэр гаргах, бодлого боловсруулах үйл ажиллагаанд үр ашигтай, тогтвортой нэвтрүүлэх явдал мөн. ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүд үүнд ихээхэн ач холбогдол өгч ажилласнаараа онцлог жил боллоо.

#### ***Манай хамт олны 2014 оны голлох үр дүнгээс дурдвал:***

Физикчид Хэд хэдэн өнгөт квант тоотой бөөмс (180-300 ГэВ масстай) оршин байвал одоо мэдэгдэж байгаа Хигс бөөмийн үүсэх, янз бүрийн сувгуудаар задрах хөндлөн огтлолуудтай зөрчилдөхгүйгээр Хигс бөөм хосоор төрөх магадлал Стандарт онолд зааснаас хамаагүй өндөр байж болохыг Лептокваркын жишээн дээр харуулав. (Tsedenbaljir Enkhbat., Scalar leptoquarks and Higgs pair production at the LHC. Nov 18, 2013. 17 pp. Published in JHEP 1401 (2014) 158)

Хэрэв Хигс орны скаляр потенциал нь Стандарт онолд зааснаас өөр, жишээ нь хөндөх бус механизмаас үүссэн бол, Хигсийн хосоор үүсэх магадлал нь өндөр байж болохыг LHC болон ILC туршилтууд дээр шалгаж болохыг харуулав (Naoyuki Haba, Kunio Kaneta, Yukihiro Mimura, Enkhbat Tsedenbaljir, Higgs Pair Production at the LHC and ILC from general potential. Oct 31, 2013. 14 pp. Published in Phys.Rev. D89 (2014) 015018)


Доктор Ц. Энхбат нарын дээрх онолын ажлуудын үр дүн нь манай эгэл бөөм, их энергийн физикийн судлаачдын баг ЦЕРН дэхь Европын цөмийн судалгааны төвийн LHC туршилтуудад хамтран оролцох боломжтойг харуулсан юм.

Хаягдал шил ба Монгол орны кварц агуулсан нэгдэл болох элсийг хайлуулан шил гарган авах технологийн горимыг тогтоож, шилийг газрын ховор элементээр хольцлон гарган авсан нь түүний гол физик шинж чанар болох тунгалагийн зэрэг (%), гулзайх температур (Tg) үзүүлэлтүүд эрс нэмэгдэж байгаа нь хаягдал шил болон эх орны түүхий эд ашиглан өндөр чанарын шил, шилэн эдлэл үйлдвэрлэх боломжтой харуулж байна.

Химичид хотирын төрлийн нэгэн зүйл ургамалд метилинозитол буюу пенитол бодис өндөр агуулгатай байдгийг тогтоосноор B8 витамин байгалийн шинэ эх үүсгэврийг

илрүүлэх боломжтой болов.

Материал судлаачид 2012-2014 онд хэрэгжүүлсэн сэдэв болон төсөлт ажлын хүрээнд дулааны цахилгаан станцын үнсийг дэвшилтэт технологиор боловсруулан геополимер төст материал гарган авах технологийг боловсрууллаа. IV ДЦС-ын шүүлтүүрийн үнсэнд суурилсан геополимер төст материал гарган авах технологийн горимыг эцэслэн тогтоож 31 МПа бат бэхийн үзүүлэлттэй геополимер төст-барилгын материалыг гарган авлаа.



### Молибденитийн баяжмалаас хатуу тослох материал гарган авах технологи


Аналитик химичид Эрдэнэтийн УБҮ-ийн молибденитийн баяжмалыг уусгалтын аргаар боловсруулсны үндсэн дээр зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа хатуу тослох материалыг гарган авах технологи, бага оврын үйлдвэрийн ТЭЗҮ боловсрууллаа.

Молибдений  
дисульфид




- Үрэлтийн коэффициент бага
- Халуун, хүйтнийг тэсвэрлэх чадвар өндөр
- Өндөр даралтыг даах чадвартай
- Эдэлгээ удаан
- Эдийн засгийн хэмнэлттэй
- Гадны нөлөөлөлд тэсвэртэй

Улаанбаатар хот, Багахангай, Багануур, Налайх дүүрэгүүд болон Эмээлтийн бүсэнд газар хөдлөлийн аюулын үнэлгээний ажлыг гүйцэтгэн газар хөдлөлтийн бичил мужлалын 10000 масштабтай зурыг зохион БХБЯ-д хүлээлгэн өгсөн байна. Эдгээр талбайд ГХБМ-ын судалгааны ажлыг хийхдээ орчин үеийн өндөр мэдрэмжтэй, тоон бичлэгтэй багаж төхөөрөмжөөр тоногдсон станцуудыг ажлуулан, мэдээллийг боловсруулах, үр дүнг гаргахдаа орчин үеийн шинэлэг арга зүйд тулгуурласан зэрэг давуу талтай юм.



Эмээлт орчмын бүс нутагт 2005 оноос эхлэн ажиглагдсан газар хөдлөлтийн идэвхжилтийн дахин боловсруулалтыг томографын аргаар (Double difference tomography) гүйцэтгэн хагарлын бүс нутгийн 3 хэмжээст хурдны загварыг тодорхойлон улмаар Эмээлтийн хагарлын бүсийн нарийвчлсан дүр зургыг гарган тайлал хийсэн байна.



Биологичид монгол оронд цөөн тоотой үлдсэн, устгах аюулд өртөөд байгаа Мазаалай баавгайн аниглалзүйн асуудлыг шийдвэрлэж, түүнийг 5000 гаруй жилийн өмнө хүрэн баавгайн зүйлээс салбарласан шинэ дэд зүйл болохыг тогтоосон нь мазаалайг хамгаалах шинжлэх ухааны үндэслэл болж байна.



Одон орон судлаачид Солонгосын Одон орон сансар судлалын хүрээлэнтэй хамтран





Тавантолгой дахь газар хөдлөлтийн станцыг түшиглэн суурилуулсан OWL дурангийн тусламжтайгаар 2014 оны сансрын хог хаягдал, хиймэл дагуулын самналт ажиглалтыг хийж, боловсруулсны дүнд сансрын хог хаягдлын каталогт бүртгэлтэй боловч алдагдсан байсан 3, бүртгэлгүй 1 шинэ объектыг тус тус илрүүлээд байна.

Бичил мөөгөнцрийн молекул ангилал зүйн аргуудыг шинээр эзэмшин ДНХ-ийг ялган, нуклеотидын дарааллыг тогтоож, филогенетик анализ хийсний дүнд эндофит мөөгөнцөрийн 6 (*Didymella*, *Stagonospora*, *Leptosphaeria*, *Neosetophoma*, *Coniochaete*, *Neofabraea*) төрлийг Монгол орны бичил биетний жагсаалтад шинээр тэмдэглэлээ.

Геологичид Хэрлэнгийн бүсийн геологийн М1:200000, Адаацагийн районы геологийн М1:100000-ын масштабтай зургуудыг тус тус зохиож, структурүүдийн геодинамикийн хөгжлийн загварыг шинэчилэн боловсрууллаа.




Палеонтологичид өвсөн идэшт бүлгийн үлэг гүрвэлийн гарал үүслийн судалгаагаар гадрозавройдын шинэ төрөл болон Троодонтидын омгийн үлэг гүрвэлийн толгойн ясны бүтцийг тогтоон Гобивенатор монголиензис хэмээх шинэ төрөл, зүйлийг олон улсад хүлээн зөвшөөрүүлээд байна.





Информатикийн хүрээлэнгийн эрдэмтэд богино зайнд байрласан анхан шатны үүсгүүрийн мэдээллийг HC-05 Bluetooth технологийн модулийг ашиглаж дамжуулах, боловсруулах програм хангамжийг бичиж туршаад тухайн аппаратыг үйлдвэрлэл хэрэглээнд нэвтрүүлэх загварыг боловсрууллаа.



Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпорацийн судлаачид Элэг хамгаалах Антомен, Бөөр хамгаалах Малбус, Ясны сийрэгжилтээс урьдчилан сэргийлэх Эгхомон, Элэг хамгаалах, хордлого тайлах Цульхирын зэрэг биологийн идэвхит хүнсний нэмэлт 4 бэлдмэлийг гарган авч, хими, технологи, эм судлалын судалгааг явуулж, технологийн зааврыг боловсруулаад байна.

Мал зүйч эрдэмтэд малын гадна шимэгчийн эсрэг өндөр идэвхитэй өвөрмөц үйлчилгээтэй Дельтатраз пурон, Дельтамон пурон, Амимектин пурон, адууны нийлүүлгийн өвчнийг анагаах Тридамон, уртасгасан үйлчилгээтэй Тетра УД 300 антибиотик зэрэг 5 эмийн технологийг боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлснээр импортын эмийг орлуулах боломж бүрдэв.

Ургамал, газар тариалангийн салбарын судлаачид буудайн Дархан-134, Дархан-34, Дархан-131 сорт болон хошуу будаа, хөх тариа зэрэг шинэ сортуудыг нутагшуулан, 30 гаруй га талбайд тариалж 200 тн элит үр үйлдвэрлээд байна.


Манай техник технологийн салбарын эрдэмтэд гэрийн зуухны туршилтын лабораторийг байгуулж, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Дэлхийн банкны Улаанбаатар цэвэр агаар төсөл, Цэвэр агаарын сантай хамтран үндэсний үйлдвэрлэгчдийн боловсруулсан гэрийн болон нам даралтын зуухны хийцийг сайжруулах үйлдвэрлэлийн цехийг байгуулсан нь нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн чухал ажлын нэг болов.

Мазаалай баавгайн амьдрах орчны загварчлалын дүнд байршил нутгийн хэмжээ ХХ зууны сүүлээс одоог хүртэл 60 гаруй хувиар багассан болохыг тогтоосон нь ихэнх судлаачдын дүгнэлттэй тохирч байгаа ба 2050 он гэхэд түүний байршил нутаг тогтвортой






байх төлөвтэй байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн (дулаарал) нөлөө хязгаарлагдмал багахан нутагт тархдаг энэ зүйл амьтанд харьцангуй бага болохыг нотолж байна. Мазаалай баавгайн ангилалзүйн асуудлыг шийдвэрлэх генетикийн судалгааны дүнд мазаалай баавгай нь Пакистанд буй Гималайн хүрэн баавгайгаас ойролцоогоор 5000-9000 мянган жилийн өмнө, харин Баян-Өлгийд буй ойн хүрэн баавгай (*Ursus arctos arctos*)-аас арай хожуу, ойролцоогоор 4000-5000 жилийн өмнө тусгаарлагдсан биеэ даасан дэд зүйл болохыг тогтоов.




Амьтан судлаач эрдэмтэд Богд хан уулын дархан цаазат газарт тархсан хөхтөн амьтдын ховордлын зэргийг Олон улсын Байгаль Хамгаалах Холбоо (IUCN)-ны шалгуураар үнэлж, бүс нутгийн хэмжээнд буюу монголд “Устаж болзошгүй” ангилалд 3 зүйл, “Эмзэг” 1 зүйл, “Ховордож байгаа” ангилалд 8 зүйл (нийт зүйлийн бүрдлийн 23,0%), “Мэдээлэл дутмаг” ангилалд 6 зүйл (зүйлийн бүрдлийн 11,5%) байгааг тогтоов.

Хивэг ашиглан малын төгс чанартай тэжээл хийх технологи боловсруулах ажлын хүрээнд гурилын үйлдвэрийн улаан буудайн хивгэнд шар сүү нэмж лактоз задлагч дрожжийн өсгөврөөр (*Kluyveromyces marxianus*) өсгөвөрлөхөд дээжний тос, нүүрс ус, илчлэг чанар нь нэмэгдэж, бусдаас давуу байгаа нь малын нэмэлт тэжээл хийх бүхэн боломжтойг тогтоон технологийн горимыг боловсруулав.





Гидробиологичид Завхан аймгийн Улаагчны Хар нуурт нийт 4 анги, 9 баг, 19 овог, 34 төрөлд хамрагдах 59 зүйлийн хөвөгч амьтад байгааг тогтоож, үүний 9 зүйлийн хүрд хорхой, 4 зүйл салаа сахалт хавч, 4 зүйлийн сэлүүр хөлт хавч нийт 17 зүйлийг шинээр бүртгэжээ.



Зураг. Хүрд хорхой-Rotatoria

Зураг . Салаа сахалт хавч – Cladocera

Монгол орны усан сангуудын амьтан, ургамлын ангилал зүйн ба амьтны аймгийн тодотголыг хийв. Монголын унаган загасны нэг Алтайн осман - /*Oreoleuciscus pewzowi*. Or. rotanini. Or. humilis/, хадран - /*Thymallus sp.*/, пельд /*Coregonus peled*/ загасны популяцийн генетик ялгарал, ангилал зүйг анх удаа молекул генетикийн судалгаагаар тодруулав.

Ургамлын ангилалзүйч эрдэмтэд “Монголын ургамлын аймаг” 20 ботит цувралын 14а ботийг хэвлүүлж, 1-р ботийн хэвлэлийн эхийг бэлдэв.

Ургамалжлын мониторингийн судалгааны дүнд мал хэт бэлчээрлэсэн ургамал бүлгэмдлийг хашиж хамгаалахад ургамлын ургах бичил орчин өөрчлөгдөж, татмын шинжийг үзүүлэгч үндсэн ургамлуудын, тухайлбал, нөхөн сэргэлт сайжирч, ургамлын биомасс эрс нэмэгддэг нь хашсан бүлгэмдэлд ургамлын цухуйц, балчир, өсвөр насны бодгалиудын сэргэн ургах чадвар дээшилдэгтэй шууд холбоотой болохыг ургамлын ценопопуляцийн судалгаагаар нотоллоо. Хэт ашиглалттай бүлгэмдлийг хашиж хамгаалах нь ургамал бүлгэмдлийг бэлчээрийн зориулалтаар ашиглах зохистой хувилбарын нэг юм.

Геоэкологичид Хангал голын усны хүнд металлын судалгаагаар голын уртын дагуух ихэнх цэгт зэс (Cu)-ийн агууламж гадаргын усны стандартаас 2-6 дахин их бохирдолттой, голын ёроолд хүнцэл (As), зөөлөн цагаан (Cd), зэс (Cu) зэрэг элементүүд маш ихээр хуримтлагдсан байгааг хагшаасанд хийсэн шинжилгээгээр тус тус тогтоогоод байна. Дархан, Эрдэнэт хот орчмын цасны усанд хийсэн судалгаагаар эрдсийн хэмжээ нь дулааны цахилгаан станц орчимд харьцангуй их, аммоны ион гэр хороололд болон орон сууцны дунд өндөр илэрч, автозамын сүлжээний нягтрал ихтэй газар болон төмөр замын вокзал орчимд хар тугалганы агууламж их гарсан байна.

Геоэкологичид Өмнөд говийн Сайн-Ус ба Бор хөөвөр, Долоодын говийн хотгоруудад хийж буй газар доорх усны судалгаагаар 420-920мг/л (цэнгэг-цэнгэгдүү) эрдэсжилттэй, 1-5 мг-экв/л (маш зөөлнөөс хатуувтар) хатуулагтай, анионуудаас хлор, гидрокарбонатын ион, катионуудаас натрийн ион зонхилсон ус тархсаныг гидрохимийн шинжилгээгээр тодорхойлоод байна. Мөн изотопын шинжилгээний дүнд боловсруулалт хийснээр эдгээр










талбай 14%-иар, уул уурхайн үйл ажиллагаанд өртөж эвдэрч доройтсон газар 90.5%-иар, хот, суурингийн эдэлбэр газар 11.8%-иар тус тус нэмэгдсэн байхад ойн талбай 24.4%-иар, уулын нугат хээрийн талбай 10.6%-иар, нугат хээрийн талбай 22.7%-иар, уулын хээр 8.4%-иар, хээрийн талбай 14.6%-иар, нуур тойрмын талбай 1.3-иар, тариалангийн талбай 13.3%-иар тус тус багассаныг тогтоогоод байна.

Монгол орны хүн амын нутагшил, суурьшлын орон зайн зүй тогтолыг, шинжлэх ухааны олон салбар дундын категори болох “амьдралын чанар” индексийг илэрхийлэх үндсэн 5 бүлэг шалгуур, 20 үзүүлэлтүүдээр судалж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт 48 сумын 29 суманд (60.4 хувь) амьдралын чанар индекс буурсан үзүүлэлт гарлаа.

Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Статистик үзүүлэлтүүд
Чинээлэг аж амьдрал	Амьжиргаа	Орон сууц Малчид
	Ажлал эрхлэлт	Ажилгүйдэл Ажиллах хүч
	Шилжих хөдөлгөөн	Шилжих хөдөлгөөний коэффициент
Өөрийгөө хөгжүүлэх	Хүн амын боловсрол	Дээд боловсрол Бүрэн бус дунд боловсрол
	Боловсролын үйлчилгээ	Ерөнхий боловсрол Сургуулийн өмнөх боловсрол
	Наслалт, эрүүл мэнд	Хүн амын эрүүл мэнд
Эрх чөлөө	Эрүүл мэндийн үйлчилгээ	Их эмчийн тоо Нялхсын эндэгдэл Эмнэлгийн орны тоо
	Сонгууль	Орон нутгийн сонгууль
	Харилцаа холбоо	Гар утас
Аюулгүй байдал	Байгалийн гамшиг	Том малын зүй бус хоргодол
	Гэмт хэрэг	Малын хулгай




Геологичид суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд Ононы бүсэд хамаарах Их цахир, Адаацаг, Эрдэнийн дүүргийн хэмжээнд тархсан офиолит эвшил, неопротерозой, протерозойн настай хувирмал бүрдэл, вулканоген болон маагмын чулуулгуудын бодисын найрлага, гарал үүслийн асуудлуудыг тодруулсан, Хэрлэнгийн бүсийн геологийн 1:200000-ын, Адаацагийн районы геологийн 1:100000-ын масштабтай зургуудыг зохиосноор Царигийн голын дүүрэгт урьд геологийн зураглалаар ялгагдсан протерозойн гнейс, кварцит бүхий хувирмал чулуулгийн бүрдлүүд шинээр хийгдсэн үнэмлэхүй насны тодорхойлолтоор неопротерозойд хамаарагдах нь батлагдсанаас гадна тус дүүрэгт ордовик, силүрийн боржингууд болон давхраажсан хурдасууд шинээр тогтоогдлоо. Түүнчлэн шинээр тодорхойлогдсон геохронологийн өгөгдлүүдээр Цариг, Мөрөн голуудын ай савд тархалттай тунамал ба тунамал-вулканоген зузаалгуудын зүсэлтүүд хийгдсэнээс гадна тэдгээрийн үүсжилтийн геодинамикийн асуудлыг шийдвэрлэх боломжтой боллоо.



Монгол-Солонгосын палеонтологичид 2009 онд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг Бүгийн хоолой орчмоос нэгэн аварга үлэг гүрвэлийн хэлхээ ясыг хэн нэгэн этгээд буруу аргаар ухаж авах гээд газар дээр нь эвдсэн үүр уурхайг олж, илрүүлэн малтлагыг хийж, эвдэж орхисон ясыг нь нэг бүрчлэн цуглуулж, БНСУ-ын Хуасонг хотын палеонтологийн лабораторид техник боловсруулалт, сэргээн засварлалт, харьцуулах судалгааг хамтран хийсний дүнд энэ нь Дейнохейрын хэлхээ яс болох нь тогтоосноор бараг хагас зуун жил хүлээгдсэн, учир битүүлэг байсан олон зүйлс тайлагдаж, улмаар дэлхий дахины үлэг гүрвэлийн аймгийн судалгааны түүхэнд эхнээс нь хүндтэй байр суурь эзлэн оршиж байсан махан идэшт үлэмж биет үлэг гүрвэлүүдийн улиран хувьслын өргөн далайцтай хувирал өөрчлөлт, дасан зохицолгооны чиг хандлагыг яруу тодоор илэрхийлэх, эртний шим ертөнцийн судлалд сүүлийн 50-аад жилийн хамгийн томоохон нээлтийн нэгд зүй ёсоор орсон байна. Энэ судалгааныхаа үр дүнг манай судлаачид 2014 онд Байгалийн шинжлэлийн нээлтийн түвшинд хийгдсэн судалгааны үр дүнг нийтэлдэг шинжлэх ухааны «NATURE» сэтгүүлд хэвлүүлснээр Монгол орны эртний шим ертөнц, дэлхийн үлэг гүрвэлийн аймгийн түүхэн хөгжлийн бас нэг томоохон нууц ийнхүү тайлагдав.



Өвсөн идэшт /Hadrosauroid/ бүлгийн үлэг гүрвэлийн өвөг удмын холбоо харилцаан дээр үндэслэсэн ангилалзүйн судалгааг гүнзгийрүүлэн хийж, жодохтын цаг үеийн хөгжлийн доод шатны гадрозаврын дэвшилтэт хэлбэрийн морфологи онцлогийн нэмэлт мэдээллийг тодотгох судалгааг хийв. Судалгааны дүнд гадрозавроидын Плезиохадрос жодохтаензис (*Plesiohadros djadokhtaensis* Tsogtbaatar et al., 2014) шинэ төрөл, зүйл, махан идэшт Троодонтидын омгийн үлэг гүрвэлийн толгойн ясны бүтцэд хийсэн судалгаагаар Гобивенатор монголиензис (*Gobivenator mongoliensis* Tsuihiji et Tsogtbaatar, 2014) хэмээх шинэ төрөл, зүйл тогтоогдож, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хэвлэгдэв.



**HADROSAURS**  
EDITED BY DAVID A. SBERTH AND DAVID C. EVANS

**An exquisitely preserved troodontid theropod with new information on the palatal structure from the Upper Cretaceous of Mongolia**

Takashi Tsuihiji · Riechen Barbold · Maho Watanabe · Kibidagva Tsogtbaatar · Tsogtbaatar Chinzorig · Yoshio Kajiwara · Miquel Brunet

Received: 7 October 2013 / Accepted: 1 December 2013 / Available online: 3 January 2014  
© Springer-Verlag Berlin Heidelberg 2014

**Abstract** Troodontidae is a clade of small-bodied theropod dinosaurs. A new troodontid, *Gobivenator mongoliensis* gen. et sp. nov., is described based on the most complete skeleton of a Late Cretaceous member of this clade presently known, from the Campanian Djadokhta Formation in the central Gobi Desert. *G. mongoliensis* is different from other troodontids in possessing a preoral anterior rod of the fused premaxilla and a fossa on the mesopreopila in front of the premaxillary foramen. The skull was superbly preserved in the specimen and provides detailed information of the entire configuration of the palate in Troodontidae. Overall morphology of the palate in *Gobivenator* resembles those of *Abrosaurus* and *Archaeopteryx*, showing an apparent trend of elongation of the prepyral process of the palatine and reduction of the prepyral process toward the basal trochlea. The palatal configuration suggests that the skull of *Gobivenator* would have been distinct, but had already acquired adaptations for later evolution of cranial kinesis in birds, such as the loss of the prepyral rod and reduction in contact areas among bones.

**Keywords** Dinosaurs · Theropods · Troodontidae · Cretaceous · Palate

**Introduction**

Troodontidae is a clade of small-bodied theropod dinosaurs known from the Cretaceous strata of Asia and North America (e.g., Makovicky and Naito 2004), and presumably includes *Archaeopteryx* from the Late Jurassic of China as well (Hu et al. 2009; Xu and Godinot et al. 2011) for an obscure phylogenetic position of this theropod. This clade has been found as a close relative of birds, making its anatomy highly relevant to the discussion on the origin of birds (e.g., Currie 1995, 1997). Members of troodontids, especially articulated skeletons, are extremely rare worldwide (Makovicky et al. 2011). Whereas well-preserved troodontid specimens have been found from the Early Cretaceous formations in China in last decade (Xu et al. 2002; Xu and Naito 2004; Xu and Wang 2004), articulated, mostly complete specimens of Late Cretaceous forms are still lacking. We here report on an exquisitely preserved skeleton of a new troodontid found from the Campanian Djadokhta Formation of the Dinosaur Road locality in the central Gobi Desert. The specimen, missing middle cervical vertebrae, includes skull in lateral, parts of both hind limbs, and most of its gasteralia, representing the most complete skeleton of a Late Cretaceous troodontid presently known (Figs. 1 and 2). In particular, palatal elements are superbly preserved in the specimen, providing detailed information on the entire configuration of this part of the skull in Troodontidae for the first time.

**SYSTEMATIC PALAEONTOLOGY**  
THEROPODA, Maniraptora  
Tyrannosauria Gauthier 1986

Published online: 03 January 2014

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Нурамтын уурхайн орчимд тархсан карбоны настай гэж үзэж байсан нүүрстэй хурдсаас илэрсэн эртний ургамлын үлдэгдэл судалгаа хийж, Чекановския ригита (*Czekanowskia rigida* Heer) зүйлийг үндэслэн нүүрс агуулсан хурдсын насыг дунд юрад хамааруулах шинжлэх ухааны дүгнэлтийг гаргав.



*Czekanowskia rigida* Heer






Эрдэс боловсруулалтын технологийн хүрээлэн Ухаа худгийн нүүрс баяжуулах үйлдвэрийн угаасан нүүрсний хаягдлын нөөцийг тогтоон, чанарын үнэлгээ хийж, уг хаягдлаар шахмал түлш үйлдвэрлэх технологи боловсруулаад байна. Уг үнэлгээгээр энэхүү хаягдал гэж нэрлэгдэх 2 дахь түүхий эд үүсмэл орд нь жилдээ 4 сая тонн хэмжээнд хүрэх нөөцтэй ба Алаг тогоо, Багануур, Налайх, Шарын гол, Шивээ-Овоогийн одоогийн олборлож байгаа нүүрснээс чанарын хувьд илүү, үнэ өртөг багатай, яндангаар хаягдах хатуу тоосонцорын хэмжээ одоо 27,7 дахин, угаарын хий 4 дахин бага, шахмал түлшний стандартын бүх үзүүлэлтийг хангасан болохыг тогтоолоо.



Цаг уурчид дэлхийн уур амьсгалын загваруудын тооцооны алдааны үнэлгээг хийж, манай орны өнгөрсөн үеийн уур амьсгалын харьцангуй бага алдаатай тооцоолсон 10 загвараар Монгол орны ирээдүйн уур амьсгалын өөрчлөлтийг загварчлан, хүлэмжийн хийн ялгаралтыг их (RCP8.5), дунд (RCP4.5), бага (RCP2.6) хувилбараар тооцоолоход, энэ зууны төгсгөл 2100 оны үед хүлэмжийн агууламжаас хамааран агаарын улирлын температур одоогийнхоос 2.50-6.30 C нэмэгдэхээр байна.





Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэд “Монгол үсэг бичгийн дээж” хамтын бүтээлдээ Монгол нутагт сүүлийн хэдэн зуун жилийн турш хэрэглэж байсан төвд хэл бичиг, түүнийг сурч байсан монголчуудын өв ухааны дээж, самгарьд, төвд хэлийг галиглах ёс, түүгээр ном судар бичиж байсан жишээ, манж, хятад үг, бичгийг буулгах ёс, дөрвөлжин үсэг зэрэг олон зүйл үсэг хэрэглэж байсан сонирхолтой баримтуудыг анхлан тусгасан.

Түүхийн хүрээлэн “ХҮII зууны Монголын хот суурин” төслийн хүрээнд Өндөр гэгээн Занабазарын (1654-1680) байгуулсан Сарьдагийн хийдийн туурийн малтлага судалгаа хийж, уг барилгуудын бүтэц, онцлогийг тодруулж, цаашид монголын бурхны шашны соёлын өв болох шавар, металл хийцийн бурхад, цац болон бусад дурсгалуудыг авран хамгаалах, нэхэн судлах нэн шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.



Түүнчлэн Сарьдагийн хийдэд археологийн үндэсний экспедиц ажиллуулахын зэрэгцээ Эгийн голын усан цахилгаан станц барих ажлын хүрээнд археологийн авран хамгаалах ажил зохион байгуулж олон шинэ эх хэрэглэгдэхүүн илрүүлэн судалгааны эргэлтэнд оруулахад бэлэн болгохын хамт уул уурхайн бүс нутаг болон бусад нутагт угсаатны хээрийн судалгааны ажил зохион явуулж хүрээлэнгийн хээрийн шинжилгээний баазыг баяжуулан, судалгааны эргэлтэнд оруулаад байна.


Соёл иргэншил судлаачид Эртний Төв Азийн нүүдэлчдийн хот, суурины атласыг Монгол улс, ОХУ-ын Буриад, Тува, Чита мужийн нутаг дахь МЭӨ-II зуунаас МЭ-XVII зуун хүртэлх 1800 орчим жилийн туршид бүтээгдсэн 100 орчим хот сууринг хамруулан боловсруулав. Хот байгуулалт, уран барилгын нийтлэг болоод өвөрмөц шинж төрхийг орчин үеийн шинжлэх ухааны үүднээс нэгтгэн дүгнэлт өгсөн байна.



## ХЭВЛЭН НИЙТЛҮҮЛСЭН БҮТЭЭЛ

Манай эрдэмтэд 2014 онд 147 ном, нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл 854 (гадаадад 296, дотоодод 558), эрдэм шинжилгээний илтгэл 796 (гадаадад 255, дотоодод 541), нийт 1797 бүтээл хэвлэн нийтлүүлсэн байна. Түүнчлэн патент 7, технологи 5, стандарт 26, аргачлал, заавар, зөвлөмж 44, ТЭЗҮ, зураг, каталог 118-г гаргасан байна. Түүнчлэн “Соёлын өвийн тухай хууль”-ийн хүрээнд нийт 63 удаагийн авран хамгаалах хайгуулын судалгааг эрхлэн гүйцэтгэсэн байна.


WoS сайтын мэдээгээр Монголоос гадаадын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлийн 52,5 хувийг ШУА-ийн эрдэмтэд гаргажээ.



2015 оны 1 дүгээр сарын 8-ны байдлаар

	Хэвлүүлсэн өгүүллийн тоо	Дүнд эзлэх хувь
ШУА	850	52.5%
МУИС	399	24.7%
ШУТИС	226	14.0%
АШУҮИС	143	8.8%
Нийт	1618	100%

ШУА-ийн эрдэмтдийн бүтээлээс 11008 удаагийн ишлэл авагдсан нь монголын судлаачдын олон улсын нэр хүндтэй хэвлэлүүдэд нийтлүүлсэн бүтээлээс авсан нийт ишлэлийн 74 хувийг эзэлж байна.



2015 оны 1 дүгээр сарын 8-ны байдлаар

	Нийт ишлэлийн тоо	Дүнд эзлэх хувь
ШУА	11008	74.0%
МУИС	2532	17.0%
ШУТИС	822	5.5%
АШУУИС	521	3.5%
Нийт	14883	100%



## ИННОВАЦИ

ШУА-д судалгааны үр дүнд боловсруулсан 102 патент байгаагаас баялаг бүтээх эргэлтэд оруулах зорилгоор шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн баг байгуулан ажилласанаар хэд хэдэн технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Тухайлбал, байгальд ээлтэй EM технологийг нутагшуулан кальцжуулсан давс цэрийн бэлдмэл, чацаргана, гүүний саам хуурайшуулах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Төрөл бүрийн хорт хавдрыг эмчлэх, урьчиланг сэргийлэх үйлдэл бүхий Дауринол агуулсан эмийн бэлдмэл үйлдвэрлэх технологийг гадаадын хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Цементийн хольцгүй, нүүрсний үнс агуулсан барилгын дүүргэгч материалын технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд бэлэн болгов.

Утаагүй түлш, биркет үйлдвэрлэлийн технологийг боловсруулж “Баялаг-эрдэнэ цом” ХХК-тай хамтран өдөрт 20 тонныг үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр Чойр хотод байгуулав.

Кракуль үүлдрийн “Сүмбэр” омог бий болгох ажлыг Говьсүмбэр аймагт хэрэгжүүлж одоогоор 2000 хоньтой болсон бөгөөд ойрын 3 жилийн дотор жилд 10000 арьс үйлдвэрлэх, 10000 толгой малтай болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Хаягдал шилийг дахин ашиглах улмаар хавтгай шил, бэлэг дурсгалын зориулалттай шил, шилэн бүдээгдэхүүн үйлдвэрлэх техникийн нөхцөл, үйлдвэрлэлийн технологийг боловсруулав.

Нийслэлийн гудамж, замын гэрэлтүүлэгийн автомат удирдлагын систем боловсруулж 490 сая төгрөгийн гэрээт ажил гүйцэтгэв.

Хэнтий аймгийн Бор-өндөр суманд байрлах “Хар төмөртэй”, “Баргилт-овоо” ордуудын төмрийн хүдрийг нойтноор баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г боловсруулсан бөгөөд тус үйлдвэр жилд 620 мянган тонн хүдэр боловсруулж 200-300 мянган тонн баяжмал үйлдвэрлэж байна. Уг үйлдвэр нь бага агуулгатай (23-38%, хуурай баяжуулалтын хаягдал) төмрийн хүдрийг баяжуулан стандарт шаардлага хангасан (65%-ийн төмрийн агуулгатай) баяжмал үйлдвэрлэж байна.

Түүнчлэн “Болд төмөр ерөө гол” ХХК-ны Баянголын уурхайн төмрийн хүдрийг нойтноор баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г боловсруулахад хамтран ажиллаа. Уг үйлдвэр ашиглалтанд орсоноор жилд 2.6 сая.тн (67%-ийн төмрийн агуулгатай) баяжмал



үйлдвэрлэх юм.

БОНХЯ-тай байгаль, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөөгүй микробиологийн дэвшилтэт технологи ашиглан ус, хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, ургамал хамгаалах, хөдөө орон нутагт ажилладаг аялал жуулчлалын газруудын бохир усны цооногийг цэвэршүүлэн, эвгүй үнэрийг багасгах зэрэг чиглэлүүдээр хамтран ажиллаж байна.

ЗТЯ-ны харъяа Авто замын хяналт, ЭШС-ны төвтэй “Авто замыг бат бэх болгох, засмал замын хальтиргаа гулгааг багасгах” технологийн туршилт судалгааны чиглэлээр хамтран ажиллаж байна.

Хэнтий аймгийн Баянхутаг суманд “Орон нутгийн хөгжил, жижиг дунд үйлдвэрлэл” сэдэвт форумд оролцож малчдын дунд малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйлсэд эрдэмтдийн оролцоо сэдвээр илтгэл хэлэлцүүлж, эрдэмтдийн боловсруулсан инноваци шинэ технологиудаас танилцуулж, хамтран ажиллахаар болов.

Дорноговь аймгийн сумдын засаг дарга нарын дунд зохион байгуулагдсан жижиг дунд үйлдвэрлэл бизнесийн уулзалтад эрдэмтдийг оролцуулж ундны усыг цэвэршүүлэх, бичил биетний ЭМ технологи уурагт бэлдмэл, кальцжуулсан давс үйлдвэрлэх сүү боловсруулах зэрэг технологиудыг танилцуулав. Тус аймгийн Засаг даргын санаачлагаар аймгийн ЗДТГ-ын дэргэд эрдэмтдийн зөвлөл байгуулав.

Зуун мод хотод болсон Төв аймгийн сумдын засаг дарга нарын семинарт ШУА-ийн хүрээлэн, төвийн эрдэмтэд оролцож, судалгаа шинжилгээний үр дүн, боловсруулсан технологиудаас танилцуулж, уулзалт ярилцлага зохион байгуулав. Улмаар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим ажил, орон нутгийг хөгжлийн асуудлаар хамтран ажиллахаар болов.

“Мон металлург” компанитай ундны усыг гидро металлургийн аргаар цэвэршүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Монголын Үндэсний Их сургуультай хамтран ажиллаж, Сургалт шинжлэх ухаан үйлдвэрлэл, инновацийг хамтран хөгжүүлэх зорилгоор “Инноваци” сэтгүүлийг 2015 оноос хамтран гаргахаар бэлтгэл ажлыг зохион байгуулав.

Байгаль Орчин Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын яамтай хамтран “Байгаль орчин инновацийн дэд хөтөлбөр”-ийн санал боловсруулах ажлын хэсэгт оролцож санал боловсруулж хүргүүлэв.

ШУА-ийн дэргэдэх “Эрдэм” студи инноваци, үйлдвэрлэлийн чиглэлээр эрдэм шинжилгээний Монхимо ХХК, Само институт зэрэг 4 байгууллагын үйл ажиллагааг танилцуулсан нэвтрүүлэг бэлтгэж МҮОНТ-ээр нэвтрүүлж олны хүртээл болгов.



## ШИНЖЛЭХ УХААНЫ СУРТАЛЧИЛГАА

ШУА-ийн Академийн [www.mas.ac.mn](http://www.mas.ac.mn) вэб хуудсыг агуулга, хэлбэрийн хувьд шинэчлэн сайжруулж, Тэргүүлэгчдийн газар болон харъяа хүрээлэн төвүүдэд болсон 170 орчим үйл явдлыг сурвалжилж, фото зургийн хамт вэб хуудас, “Монгол улсын Шинжлэх ухааны академи” фэйсбүүк групп, академийн твиттер хуудсанд мэдээ мэдээллийг шуурхай, тогтмол байршуулж олон нийтийн хүртээл болгов.



Өнгөрөгч 4 дүгээр сард ШУА-ийн харъяа хүрээлэн, төвүүдийн вэб хуудсын хөгжүүлэлт, үйл ажиллагаанд судалгаа хийсний үндсэн дээр хүрээлэн, төвүүдийн вэб сайтуудыг сайжруулах, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээлэл өгөх зорилгоор 4 дүгээр сарын 28-ны өдөр Информатикийн хүрээлэнтэй хамтран хүрээлэн, төвүүдийн вэбсайт хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан сургалт зохион байгуулав. Сургалтын дараа вэб сайтгүй байсан хүрээлэн, төвүүдэд шинээр вэб сайт хийх, сервер дээр гардаг алдаануудыг засах зэрэг арга хэмжээнүүдийг авсан.

Хүрээлэн, төв тус бүрээс хэвлэл мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөө гаргуулж, биелэлтийг хангуулах үүднээс шаардлага тавин ажиллав. Улмаар хүрээлэн, төвүүд мэдээлэл, сурталчилгааны ажилд өмнөхөөсөө илүү идэвхтэй хандах болов.

**Эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүн, хийж буй ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд:**



Өдөр тутмын тогтмол хэвлэлүүд болох “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан” сонинуудтай хамтран ажиллаж 108 удаагийн материал нийтлүүлсэнээс **ярилцлага-34, мэдээ-47, сурвалжлага-6, нийтлэл-18** хэвлэгдсэн байна. Үүнээс **зар, эмгэнэл-4, нийтлэл-17, ярилцлага-2, мэдээ-17** төлбөртэй, бусад материалыг үнэ төлбөргүй нийтлүүлсэн байна. Эрдэмтэн судлаачдын хийж буй ажлыг сурталчлах зорилгоор МҮОНТ, Ийгл, С1, UBS зэрэг телевизүүдийн 57 удаагийн зочны цаг



болон мэдээний дундуурх зочны цагаар эрдэмтдийг үнэ төлбөргүй оролцуулсан байна.

Ийгл телевизтэй хамтран шинээр сонгогдсон академичдийг цуврал ярилцлагад оруулав.



Тэргүүлэгчдийн газар болон харьяа хүрээлэн, төвүүд дээр болж буй үйл явдлуудыг шуурхай сурвалжилж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангаж ажиллав. Үүнд Монгол HD, TV25, C1, МҮОНТ, TV5, Одон Тв, UBS, TV9, МҮОНРадио зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, ярилцлага, мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүргэсэн байна.

ШУА-иас нийлүүлж буй мэдээ, мэдээлэл [www.lag.mn](http://www.lag.mn), [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.orloo.mn](http://www.orloo.mn), [www.mongolnews.mn](http://www.mongolnews.mn), [www.news.mn](http://www.news.mn), [www.ugluu.mn](http://www.ugluu.mn), [www.sonin.mn](http://www.sonin.mn), [www.urlag.mn](http://www.urlag.mn), [www.top.mn](http://www.top.mn), [www.mminfo.mn](http://www.mminfo.mn), [www.olloo.mn](http://www.olloo.mn), [www.dnn.mn](http://www.dnn.mn), [www.dorgio.mn](http://www.dorgio.mn), [www.new.mn](http://www.new.mn), [www.mnb.mn](http://www.mnb.mn), [www.mn2.mn](http://www.mn2.mn), [www.mass.mn](http://www.mass.mn) зэрэг 41 цахим сайтад тавигдсан байна. Эдгээрээс [www.montsame.gov.mn](http://www.montsame.gov.mn), [www.mnb.mn](http://www.mnb.mn), [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.olloo.mn](http://www.olloo.mn), [www.news.mn](http://www.news.mn), [www.new.mn](http://www.new.mn) зэрэг хамгийн өндөр хандалттай

сайтуудтай байнга холбоотой хамтран ажиллав.



**ШУА-ийн албан ёсны facebook, twitter хуудсуудыг тогтмол ажиллуулах, өргөжүүлэх, олон нийтийн сүлжээгээр дамжуулан эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд:**

Facebook, Twitter-т цаг үеийн мэдээ мэдээллийг тэр даруй шуурхай оруулж ажилласан бөгөөд одоогоор академийн фэйсбүүк групп нийт **3493**, твиттер хуудас **1190** гишүүнтэй болон өргөжиж, шинжлэх ухаан сонирхогчдын тоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байна.

Улмаар facebook группээр дамжуулан шинжлэх ухааны салбарыг сонирхогчид нээлттэй үзэл бодлоо хэлэх боломжтой болсон бөгөөд тодорхой санал, гомдлуудыг шийдвэрлэж ажиллав.

**Монголын шинжлэх ухааны ажилтны өдрийг тэмдэглэх үйл ажиллагааг сурталчлах төлөвлөгөө гарган ажиллах ажлын хүрээнд:**

Баярын өдрийг тохиолдуулан Өдрийн сонин, Үндэсний шуудан сонинтой гэрээ хийн ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, харьяа хүрээлэн, төв тус бүр сурталчилгааны төлбөрт материалыг бүтэн нүүрээр асуудал дэвшүүлсэн нийтлэл, шинжлэх ухаан-шинэ бүтээл-инноваци, онцлох үйл явдлууд гэсэн 3 дэд хэсэгтэйгээр тус тус нийтлүүлсэн байна.



Мониторингийн судалгаагаар тус сурталчилгааны төлөвлөгөөт ажил “Өдрийн сонин”-ы 12,000, “Үндэсний шуудан” сонины 7,000 уншигчдад, нийт 19,000 хүнд шууд хүрсэн гэсэн тооцоолол байна.

“Эрдэм сонин”-ны 2014 оны №179-184 дүгээр дугааруудад “Цаг үе, үйл явдал”, “Залуу судлаачийг танилцуулж байна” булангуудыг тогтмол ажиллуулав.

БОНХЯ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 2014 онд хийсэн ажлын тайланг гаргаж, Эрдэм сонины 11-р сарын тусгай дугаарт нийтлэл бичиж, сурталчлав.

Монголын хамгийн олон уншигчтай сонинууд болох Өдрийн сонин, Засгийн газрын мэдээ сонинуудтай, хамгийн их хандалттай мэдээллийн сайтууд болох [www.news.mn](http://www.news.mn), [www.gogo.mn](http://www.gogo.mn) сайтуудтай 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс төлбөртэй гэрээ байгуулан ажиллахаар тохиролцов. Ингэснээр манай бүхий л мэдээ мэдээлэл цаг алдалгүй маш олон хүнд хүрэх боломжтой юм.

Шинжлэх ухааны сонирхон судалдаг 40 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслийн 100 орчим сэтгүүлчийг эгнээндээ нэгтгэсэн “сүлжээ” үүсгэсэн байна. Улмаар гэрээлэн ажилладаггүй ч Eagle tv, C1 тв, Парламент тв, МҮОНРадио, Монцамэ агентлаг, Үндэсний шуудан сонин, Засгийн газрын мэдээ сонин, [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.new.mn](http://www.new.mn), [www.mnb.mn](http://www.mnb.mn), [www.montsame.gov.mn](http://www.montsame.gov.mn) зэрэг нь манай мэдээ мэдээллийг шаардлагатай үед тухай бүрт олон нийтэд хүргэв.

Эко телевизээс бэлтгэдэг “Тэнгэрлэг бүтээлүүд” цуврал нэвтрүүлэгтэй хамтран ажиллаж эхнээсээ нэвтрүүлэг гарч эхлээд байна. Эхний нэвтрүүлэгт академич Д.Доржготов оролцсон бөгөөд одоо М.Төмөржав, А.Дулмаа, Р.Барсболд, Б.Энхтүвшин, О.Төмөртоогоо зэрэг 10 гаруй эрдэмтнийг оролцуулахаар бэлтгэж байна.

ETV-2 телевиз, Сам энтэртайменттэй хамтран “Судлаачийн тайлбар” цуврал нэвтрүүлгийг хийж нэвтрүүлж эхлээд байна. Хамтран ажиллах гэрээнд зааснаар нэвтрүүлэгт академийн хүрээлэн, төвд ажилладаг эрдэмтэн судлаачид маш идэвхтэй оролцож ажиллав. Одоогоор 4 удаагийн нэвтрүүлэг /тус бүр 30 мин/ нэвтэрсэн байгаа бөгөөд цахим орчинд давхар байрлуулсанаар маш их хандалт авч олны анхаарлыг аль хэдийн татаад эхэлсэн байна. Тухайлбал эхний бэлтгэсэн “Улаанбаатар хотын ундны усны аюулгүй байдал” нэвтрүүлэг **22,317** хүнд хүрсэн бол “Тэдэнд яагаад тусалддаггүй вэ?” нэвтрүүлэг **12,000** хүнд хүрсэн байна. Цаашид энэхүү нэвтрүүлгээр дамжуулан тулгамдсан асуудлаар эрдэмтдийнхээ дуу хоолойг олон нийтэд хүргэж байхаар төлөвлөн ажиллаж байна.

Дэлхий нийтээр өргөн тэмдэглэдэг олон улсын тэмдэглэлт өдрүүдийн жагсаалт гаргаж түүнд холбогдох сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:



2014 оны туршид дэлхий нийтээр өргөн тэмдэглэдэг **16** өдрүүдийн хүрээнд сонин, телевиз, радиотой хамтран хүрээлэн, төвийн эрдэмтэн судлаачдыг оролцуулсан **18** удаагийн ярилцлага, сурвалжлагыг хүргэсэн байна.

Шинжлэх ухаан, боловсролын нягт хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглаж байгаа байгаль шинжлэл, амьгүй байгалийн сурах бичгүүдэд зөвлөмж боловсруулав.

ЕБС-ийн сурагчдын ургамал судлалын онолын мэдлэгийг баталгаажуулахад шаардлагатай дадлагын хичээлийн үзүүлэн таниулах материал, тухайлбал, Монгол оронд өргөн тархалттай 37 овог 140 төрөлд хамаарах **186** зүйл гуурст дээд ургамал, 25 зүйл доод (замаг, мөөг, хаг) ургамлын онцлог шинжийг харуулсан **70** ширхэг зурган үзүүлэн (CD –ийн хамт), **20** гаруй тогтмол препаратыг бэлтгэж өгөх ажлыг санаачилж, төслийг БШУЯ-нд өгөөд байна.

Мэдлэгийн хэрэглээг өргөтгөж, шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, ЕБС-ийн багш, сурагчид, иргэдийн танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилго бүхий “Амьдралын үүсэл”, “Генетикийн гайхамшиг”, “Ертөнцийн үүсэл”, “Монголчуудын уг гарвал”, “Монгол нутаг бол археологийн баян галерей”, “Шинжлэх ухаан ба Шашин”, “Монголын эртний тэнгисийн амьтан ургамал”, “Эрчим хүчийг яаж гарган авдаг тухай”, “Экологи ба амьтад”, “Монгол орны геологийн өвөрмөц тогтоц”, “Нано технологи гэж юу вэ”, “Анагаах ухаан” зэрэг сэдвээр шинжлэх ухааны хялбаршуулсан цуврал ном гаргаад байна.



## ЭРДЭМ КЛУБ

Монгол улсын ШУА нь шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон эрдэм дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх, лектори зохион байгуулах зорилгоор “Эрдэм клуб”-ыг байгуулан үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Эрдэм клубын зөвлөл нь шинжлэх ухааны судалгаагаар




бий болсон үр дүнд тулгуурлан улс орны хөгжлийн бодлогыг боловсруулах, тулгамдсан асуудлыг цаг алдалгүй зохицуулахад эрдэмтэдийн хүчийг ашиглах, улс төрчид, төрийн захиргааны байгууллагатай эрдэмтэдийг холбох гүүр болох зорилт тавин ажиллаж байна.

## АКАДЕМИЧДЫН ЦУВРАЛ ЛЕКЦ

Олон түмнийг соён гэгээрүүлэх, эрдэм түгээн дэлгэрүүлэх албан болон албан бус боловсролын хүрээнд идэвхитэй ажиллаж, иргэд, олон нийт, шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй удирдах ажилтан, эрдмийн хамт олондоо “Академичдын цуврал лекц” зохион байгуулж, уул уурхай, эрчим хүч, барилга, эрүүл мэнд, эдийн засаг, хэл шинжлэл, хими, физик, цөмийн эрчим хүч, ашигт малтмалд тулгуурласан дэвшилт технологи, биотехнологийн онол практикийн асуудал, математик ба хэрэглээний чиглэлээр лекц уншиж олны хүртээл болгосныг МҮОНТ, Eagle телевиз, Эх орон телевизээр орон даяар нэвтрүүлэн, өдөр тутмын “Өдрийн сонин”-д бүх лекцийн хураангуйг цувралаар нийтлүүлэн нийтийн хүртээл болголоо.


2014 онд академич Д.Хайсамбуу “Монгол уран барилгын хөгжил, онол, арга зүй” сэдвээр, академич Н.Бэгз “Монголын боловсрол судлалын хөгжлийн асуудлууд” сэдвээр, академич Х.Намсрай “Орчин үеийн физикийн шинжлэх ухаан ба ирээдүйн авьяасыг нээх зарим арга зам” сэдвээр тус тус лекц уншсан бөгөөд лекцэнд 800 гаруй хүн шууд оролцож, лекцийн хураангуйг “Өдрийн сонин”-д хэвлэн олон нийтийн хүртээл болгов.





## ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН МЭДЭЭ СЭТГҮҮЛ

“Шинжлэх ухааны Академийн мэдээ” сэтгүүлд 2014 онд хэвлүүлэхээр ирүүлсэн монгол хэл дээрх 31, гадаад хэл дээрх 11 өгүүллийг цаасан болон файл хэлбэрээр хүлээн авч ерөнхий редакторт танилцуулж, экспертийн уншилтад оруулж хэвлэн гаргаж байна.




Mongolian Journal of International Affairs	MJIA
Proceedings of the Mongolian Academy of Sciences	PMAS
Mongolian Journal of Chemistry	MJC
Mongolian Journal of Agricultural Sciences	MJAS
Journal of International Studies	JIS

Шинжлэх ухааны Академийн мэдээ (PMAS) сэтгүүлийн 1961 оноос хойших 212 дугаар бүхий хэвлэмэл сэтгүүлийг цахим хувилбарт оруулах ажлыг эхлүүлэн онлайн хувилбарыг Олон улсын шинжлэх ухааны холбоо (ICSU)-ийн INASP хөтөлбөр, ([www.mongolijol.info](http://www.mongolijol.info)) -тай хамтран байршуулж, олны хүртээл болгож байгаа бөгөөд Академийн цахим хуудсанд холбоос цэсийг үүсгэн нэмэлт баяжуулалтыг хийж байна. ШУА-ийн Мэдээ сэтгүүлийг цахим хуудсанд байршуулснаас хойш нийт 46'537 удаагийн татан авалт хийгдсэн байна.



## ШИНЖЛЭХ УХААН АМЬДРАЛ СЭТГҮҮЛ

Улирал тутмын тогтмол хэвлэл “Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүлийн 332-335 дахь дугаарыг эрхлэн гаргаж Төв шуудан, Түгээмэл шуудан, Интер ном худалдааны төвөөр дамжуулан олны хүртээл болж байна.



## ЭРДЭМ СОНИН

Шинжлэх ухааны ололт, амжилт, нэрт эрдэмтдийн бүтээл туурвил, арга барил, залуу эрдэмтдийн шинэ соргог санаа сэдэл, Монголын болон Дэлхийн шинжлэх ухааны баялаг түүхийн хуудас, өнөөдрийн ололт амжилт, ШУА-ийн хүрээлэн, төв болон Монгол улсын хэмжээнд хөгжиж буй шинжлэх ухаан технологи, судалгаа шинжилгээний өдөр тутмын болон онцлох үйл явдлыг сурвалжлах шинжлэх ухаан танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг багтаасан ШУА-ийн сар тутмын “Эрдэм” сонины 12 дугаар эрхлэн гаргаж эрдэмтэн судлаачид, нийтийн хүртээл болгон ажиллав.





“Эрдэм сонин”-ны 2014 оны №179-184 дүгээр дугааруудад “Цаг үе, үйл явдал”, “Залуу судлаачийг танилцуулж байна” булангуудыг тогтмол ажиллуулав.

Шинжлэх ухааны үр дүнг олон нийтийн хүртээл болгох зорилгоор Монгол улс, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойд зориулсан “Талын дайчдын өв соёл” үзэсгэлэнд Баянхонгор, Ховд, Өвөрхангай аймгийн нутагт малтан судалсан хадны оршуулгын 170 гаруй эх хэрэглэгдэхүүнийг дэлгэн үзүүлж олны хүртээл болгосон бөгөөд нийт 55 мянга гаруй хүн үзэж сонирхов.





## САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР

ШУА-ийн харъяа хүрээлэн, төвүүдэд 2014 онд Нийт 711,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг батлуулав. Үүнд: компьютер, ширээ, сандал тус бүр 164 ширхэг, Газарзүйн хүрээлэнгийн Цэвдэг судлалын лабораторийн багаж, Физик технологийн хүрээлэнгийн Наноматериалийн судалгааны багаж, Эрдэс боловсруулалт технологийн хүрээлэнгийн барилгын дээвэр, фасадны их засвар зэрэг багтсан болно.



ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар болон харъяа хүрээлэн төвүүдийн 2015 оны барилгын их засвар, хөрөнгө оруулалтын санал, холбогдох үндэслэлийг боловсруулж БШУЯ, СЯ-нд хүргүүлэв. Үүнд: Хөрөнгө оруулалтад 5 барилга 9 тэрбум, 7 хүрээлэнгийн барилгын засварт 500 сая, багаж, тоног төхөөрөмж 10,5 тэрбум.

ШУА-ийн харъяа хүрээлэн, төвүүд 2014 онд 4.1 тэрбум төгрөгийн төсвийн гадуурх орлого олсон байна.

### ШУА-ийн харъяа хүрээлэн, төвийн 2014 оны төсвийн гадуурх орлого

/мян.төг/

Д/д	Хүрээлэн, төв	Орлого
1	Одон орон, геофизикийн судалгааны төв	2,873,447.00
2	Геоэкологийн хүрээлэн	343,000.00
3	Палеонтологийн төв	89,797.00
4	Биологийн хүрээлэн	12,395.00
5	Археологийн хүрээлэн	46,016.00
6	Ботаникийн хүрээлэн	111,043.00
7	Геологи, эрдэс баялгийн хүрээлэн	108,384.00
8	Информатикийн хүрээлэн	181,893.65
9	Физик технологийн хүрээлэн	22,500.00
10	Хэл зохиолын хүрээлэн	2,444.00
11	Газарзүйн хүрээлэн	78,000.00
12	Олон улс судлалын хүрээлэн	28,600.00
13	Хими, хими технологийн хүрээлэн	10,674.00
14	Философи, социологи, эрхийн хүрээлэн	27,000.00
15	Түүхийн хүрээлэн	153,830.20
16	Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв	5,080.00
17	Байгалийн шинжлэлийн нэгдсэн лаборатори	3,485.00
	<b>Нийт</b>	<b>4,097,588.85</b>





## ДҮГНЭЛТ

---

2014 онд судалгаа, шинжилгээний ажил хийх нөхцөл, орчин мэдэгдэхүйц сайжраагүй боловч манай эрдэмтэд шинэ мэдлэг үйлдвэрлэх, мэдлэгээ амьдралд нэвтрүүлэх чиглэлээр амжилттай ажиллалаа.

1. Шинжлэх ухааны академи төр, засгийн байгууллагуудтай судалгаа шинжилгээний ажлын бодлогын орчинг сайжруулах чиглэлээр ажилласны үр дүнд УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2014 оны 04 сарын 23-ны өдрийн 07 тоот тогтоол гарсан нь манай салбарын бодлогын орчинд чухал үйл явдал боллоо. Цаашид тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах нь чухал байна.

2. Төр, засгийн байгууллагуудшийдвэр гаргахад нь зориулсан шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогын зөвлөмж боловсруулах үйл ажиллагаа идэвхитэй хөгжиж байна. Нийт 44 бодлогын зөвлөмж боловсруулжээ.

3. Орон нутгийн хөгжилд шинжлэх ухааны салбарын зөвлөмж, захиалгат ажлыг манай эрдэмтэд амжилттай гүйцэтгэж, энэ чиглэлд 2012 онд эхлүүлсэн бидний үйл ажиллагаа улам боловсронгуй болж байгааг тодорхой жишээнүүд нотолж байна.

4. Манай эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд инновацийн чадавхитай байгааг манай хими, хими технологийн хүрээлэн болон “Баялаг эрдэнэ цом” ХХК-тай хамтарсан технологи дамжуулах үйл ажиллагаа тодоор харууллаа. Монгол улсын үндэсний үйлдвэрлэгчид энэ компанийн туршлагаас суралцаж болно гэж үзэж байна.

5. Их, дээд сургуулиудтай хөгжүүлж буй манай хамтын ажиллагаа улам эрчимжиж байгаад бид баяртай байна.

6. Эрдэмтдийн бүтээлийг олон улсын түвшинд хүртээл болгох зорилгоор ICSU-ийн INASP санаачилгын хүрээнд онлайн сэтгүүлүүдийг гаргаж байгаа нь амжилттай болж байна.

7. Гадаад харилцаа амжилттай хөгжиж ирлээ. Бид энэ онд 9 улсын 13 байгууллагатай шинээр гэрээ байгуулав.

8. “ШУА-ийн хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулан, одоо үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд бэлтгэж байна.





## ЗОРИЛТ

---

Шинжлэх ухааны салбарт бүтцийн өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан ойрын үед энэ өөрчлөлттэй үйл ажиллагаа, дотоод бүтцээ боловсронгуй болгох, менежментээ уялдуулах шаардлага тулгарч байна. Үүний зэрэгцээгээр бид дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

1. Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай байна;

2. “ШУА-ийн хүний нөөцийн бодлогын баримт бичиг” “Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө”-г хэлэлцэн баталж, ШУА-ийн докторантурын сургалт зохион байгуулах журам боловсруулж, батлуулах;

3. Төр, засгийн байгууллага, орон нутаг, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх;

4. Их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн, Их дээд сургуулийн консорциумтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;

5. ШУА-ийн бүтцэд Эдийн засгийн судалгааны нэгжийг бий болгох;

6. Шинжлэх ухааны салбарын сэтгүүлүүдийг онлайн хэлбэрээр олон нийтийн хүртээл болгох ажлыг улам өргөжүүлнэ;

7. Инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэн оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гарааны компани байгуулах чиглэлээр идэвхтэй ажиллана;

8. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, хамтарсан судалгааны төсөл 2-ыг шинээр хэрэгжүүлж эхэлнэ;

9. 2015 оныг “Шинжлэх ухааныг сурталчлах – түгээн дэлгэрүүлэх” жил болгон зарлаж, тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.



